



implemented by
giz

“МОНГОЛ ДАХЬ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ” ТӨСӨЛ (2018-2021)



БИДНИЙ ТУРШЛАГА-2021

“Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх” төслийн хүрээнд 2021 онд Нийслэлийн цэцэрлэг, сургуулиудын хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, сайн туршлагын эмхэтгэл

Улаанбаатар хот
2021 он



**НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
“ХӨГЖИЛ” ЦОГЦОЛБОР СУРГУУЛЬ**



БИДНИЙ ТУХАЙ

Манай сургууль 1985 онд Сонгинохайрхан дүүргийн, Октябрийн район нутаг дэвсгэрт 900 хүүхдийн багтаамжтайгаар байгуулагдсан. Одоогоор Сонгинохайрхан дүүргийн 12, 13, 14, 30, 31, 43 дугаар хорооны хүүхдүүдийг хамран сургадаг, хичээлийн хоёр байртай .

2021-2022 оны хичээлийн жилд 123 бүлгийн 4881 хүүхдийг сургаж 174 багш, 53 ажилчдтай үйл ажиллагаагаа явуулж байна. 100 хувь мэргэжлийн багш нараар хангагдан. Математик, Хими, Дүрслэх урлаг зэрэг төрөлжсөн болон гүнзгийрүүлсэн сургалттай ангиуд хичээллэдэг.

**“МОНГОЛ ДАХЬ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШГИЙГ
ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ’ ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ МАНАЙ СУРГУУЛЬ**

С.Энх-Ариун (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын Хөгжил цогцолбор сургуулийн захирал)

Манай сургууль нь энэхүү төсөлд хамрагдсанаар хичээлийн 2-р байрны дээврийн хэсэгчилсэн засварыг шинээр хийж гүйцэтгэлээ. Төслийн Үр шимийг 4881 хүн хүртэж байгаа бөгөөд бөгөөд 2 давхарын ангиудын суралцагчид, багш, ажилчид, эцэг эхчүүдийн сэтгэл хангалуун байна. Өмнө нь сургууль дээврээс дусаал гоождог байсан. Учраас хүүхэд, багш, ажилчид ажиллах хүндрэлтэй асуудлууд тулгарч ажиллах нөхцөл таагүй, сэтгэл санаа тав тухгүй байдаг байсан. Энэ оны 10-р сараас дээрх нөхцөл байдал өөрлөгдөн. Бид дулаахан, ая тухтай орчинд ажиллаж эхэллээ. Ингэснээр сургалтын чанар, сурагчид эрүүл аюулгүй орчинд суралцах орчныг бүрдүүлж чадсан.



Сургууль энэхүү төсөлд хамрагдсанаар, Төсөл хэрэгжих хугацаанд хичээлийнхээ нэг, хоёрдугаар байрандаа эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан, дотоод, гадаад орчинд хяналт – шинжилгээ үнэлгээг, сургуулийн “Дэмжих баг”-ийн гишүүд болон эцэг эхийн оролцоон дээр тулгуурлан хийж гүйцэтгэсэн, хийсэн хяналт – шинжилгээ, үнэлгээндээ анализ дүн шинжилгээ хийж, сургуулийн орчинд нэн шаардлагатай байгаа ариун цэврийн 3 өрөөг шинээр хийж ажиллаж байна. Төслийн үр шимийг 4881 хүүхдүүд, багш ажилчид хүртэж байгаа бөгөөд сэтгэл хангалуун байна. Өмнө нь сургуулийн суралцагчид ариун цэврийн өрөөнд орход хүндрэлтэй зүйлүүд олон байсан бөгөөд сэтгэл санаа тав тухгүй байдаг байсан. Энэ оны 09-р сараас дээрх нөхцөл байдал өөрчлөгдсөн. Орчин үеийн стандартад нийцсэн, дулаахан, ая тухтай орчныг бий болгон ажиллаж эхэллээ. Ингэснээр сургалтын чанар, сурагчдын төлөвшилд эерэг өөрчлөлтүүд гарч байна. Мөн төсөл хэрэгжих хугацаанд багш нар нийгмийн хариуцлагын хүрээнд сургуулийн хог хаягдлын Асуудлыг онцлон анхаарч ажилласны үр дүнд 3 ангилсан хогийн савтай болж, хогийг ангилан ялгах арга зүйд хамт олноороо суралцаж байна. Цаашид нийт сургуулийнхаа бүх анги танхимд ангилсан хогийн савтай болох ажлыг эхлүүлэн. Энэхүү ажилд хяналт тавин ажиллаж байна.

**ХИЧЭЭЛИЙНХЭЭ НЭГ, ХОЁРДУГААР БАЙРАНД 3 АРИУН ЦЭВРИЙН
БАЙГУУЛАМЖИЙГ БҮРДҮҮЛСЭН НЬ**

Сайн туршлагын нэр:	“НЭГ СЭТГЭЛ – НЭГ ЗОРИЛГО” ТӨСӨЛ
Зорилго	Сургуулийн нийт эцэг эхийн оролцоотойгоор хичээлийн нэг, хоёр дугаар байрны сурагчид болон багш ажилчдад цэвэрхэн тав тухтай, орчин үеийн стандартад нийцсэн, ариун цэврийн өрөөтэй болж, эрүүл ахуйн шаардлага хангасан, эрүүл аюулгүй орчинд сурч боловсрох орчныг бий болгох.
Нөхцөл байдал, тулгамдсан асуудал	Хичээлийн нэг, хоёр дугаар байрны хувьд тулгамдсан асуудал нь сурагчдын ариун цэврийн өрөө нь стандарт чанарын шаардлага хангахгүй байгаа нь сурагчдад тулгамдаад байсан нэн шаардлагатай асуудлын нэг байсан. Энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд сургуулийн хичээлийн нэг, хоёрдугаар байранд 3 ариун цэврийн өрөөг шмнээр нэмж засварлан тохижуулах ажлыг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгээд, засварын ажлыг хийж дуусгаж тулгамдсан асуудлаа шийдвэрлэж чадсан.
Зорилтот бүлэг	123 бүлгийн 4881 сурагч, 227 багш ажилчидтай, 9700 гаруй эцэг эх, асран хамгаалагч
Шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> • Ариун цэврийн ажлын гүйцэтгэлийн хувь • Эцэг эхийн оролцооны гүйцэтгэлийн хувь • Багш ажилчдын оролцооны гүйцэтгэлийн хувь • Гүйцэтгэгч компанийн ажлын гүйцэтгэлийн хувь • Дээврийн ажлын гүйцэтгэлийн хувь • Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь
Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат	<p>Эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулж явуулсан байдал</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Сургуулийн хичээлийн нэг, хоёрдугаар байрны гадаад, дотоод орчинд эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг 105 эцэг эхтэй хамтран хийж гүйцэтгэсэн • Үнэлгээ үр дүнг, хяналтын үйл ажиллагаанд оролцсон 105 эцэг эхчүүдтэйгээ цахимаар хуралдан үр дүнг тооцон нэн шаардлагатай байгаа асуудлыг эрэмбэлэн боловсруулахад дараах 4 асуудал дээр санал хэлэлцсэн. 1. Хашаа засварлах, 2. Гадна орчны гэрэлтүүлэг, 3. Сургуулийн орчмын тэмдэглэгээ 4. Суралцагчдын ариун цэврийн өрөөг засварлах гэсэн асуудлуудыг ярилцан санал хураач хуралд оролцсон эцэг эхчүүд 60 хувь нь ариун цэврийн байгууламжийг засварлахаар дэмжсэн. • Эцэг эхийн төлөөлөл болон дэмжих багийн гишүүд анги удирдсан багш нар бусад эцэг эхчүүддээ мэдээллийг

	<p>цахимаар хүргэн асуудлыг танилцуулан санал бодлыг нь сонсон дэмжиж байгаа эсэхийг тодруулан. Зохион байгуулах ажлаа танилцуулан ажиллахад сургуулийн нийт эцэг эхчүүд дуу нэгтэйгээр дэмжин хөрөнгө санхүү босгох хандивын ажлыг эхлүүлэн ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> • Ариун цэврийн өрөөний заслын ажлыг “СЭЦҮҮ БУЛАГ” ХХК-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн. • Ариун цэврийн өрөөний хаалт, хаалгыг “МООК ДИЗАЙН” ХХК-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн. • Төслийн хүрээнд сургуулийн багш нарын оролцоотой орчин үеийн стандарт, 3 ангилсан хогийн савыг бий болгосон. Цаашид сургуулийн бүх ангийг гурван ангилсан хогийн савтай болгох ажлыг эхлүүлэн, мэргэжилтэнд хяналт тавин ажиллаж байна. • Дээврийн хуучин хар цаасыг хуулуулсан • Дээврийн цутгалт дээр стандартын дагуу хийгдэж байгаа эсэхэд Дэмжих багийн гишүүдийн оролцоотой хяналт тавин ажиглалт хийэ ажилласан • Барилгын ажилтнуудад хөдөлмөр аюулгүй байдлаа хангаж ажиллах талаар ажилтнуудад анхааруулж ажилласан • Бусад ариун цэврийн өрөөнүүддээ ноолын цаас тогтоогч, шингэн савангийн сав тогтоогч, салфеткны, гар ариутгагч, суултуур таг зэргийг нэмэлтээр хийж гүйцэтгэсэн.
<p>Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)</p>	<ul style="list-style-type: none"> • Сургуулийн нийт эцэг эхийн оролцоотойгоор хичээлийн нэг, хоёр дугаар байрны сурагчид болон багш ажилчдад цэвэрхэн тав тухтай, орчин үеийн стандартад нийцсэн ариун цэврийн өрөөтэй болж, эрүүл ахуйн шаардлага хангасан, сэтгэл хангалуун, эрүүл аюулгүй орчинд сурч боловсрох орчин бүрдсэн. • Суралцагчд ариун цэврийн өрөөнд зөв боловсон орж, бусдад эерэг хандлагыг түгээж байгаа • Тогоо, усаа хэмнэх зэрэг эерэг өөрчлөлтүүд гарч байна. • Бусад ариун цэврийн өрөөнүүддээ нойлын цаас тогтоогч, шингэн савангийн сав тогтоогч, салфетикийн, гар ариутгагч, суултуур таг зэргийг нэмэлтээр хийж гүйцэтгэсэн. • Хичээлийн 1, 2-р байрны хуучин 8 хаалгыг шинээр хийж гүйцэтгэсэн сурагчдын аюулгүй байдлыг ханган • Хичээлийн хоёр байрны камерыг шинэчлэх ажил 90 хувьтай явагдаж байна.
<p>Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд</p>	<ul style="list-style-type: none"> • Бусад ариун цэврийн өрөөнүүддээ нойлын цаас тогтоогч, шингэн савангийн сав тогтоогч, салфетикийн, гар ариутгагч, суултуур таг зэргийг нэмэлтээр хийж гүйцэтгэсэн. • Төслийн хүрээнд сургуулийн багш нарын оролцоотой орчин үеийн стандарт, 3 ангилсан хогийн савыг бий болгосон. Цаашид сургуулийн бүх ангийг гурван ангилсан хогийн

БИДНИЙ ТУРШЛАГА-2021

	<p>савтай болгох ажлыг эхлүүлэн, мэргэжилтэнд хяналт тавин ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Суралцагчдад зөв боловсон ариун цэврийн өрөөнд орох зөвлөмж санамжийг байршуулсан • Ус, цахилгаанаа хэмнэе гэсэн уриалга, зөвлөмж санамжийг байршуулан ажиллаж байна. • Дулаан алдалт байхгүй, тог, цахилгаан сантехникийн хувд асуудалгүй эдийн засгийн хувьд хэмнэлттэй, үр дүн бий болж байна.
Тулгарсан бэрхшээл, эрсдэл:	<ul style="list-style-type: none"> • Ажлын зураг хийлгэх мэргэжлийн хүн олдоогүй үнэ өртөг өндөр • Барилгын засварын ажлын хөлс өндөр • Барилгын материалын үнэ өссөн • Ерөнхий зураг хийлгэж чадаагүй
Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> • Сургуулийн орчинд хяналт шинжилгээ үнэлгээг хэрхэн хийх аргачлал • Аливаа ажлыг зохион байгуулж хийхдээ тухайн ажлаа олон нийтэд маш сайн сурталчилан таниулах түгээн дэлгэрүүлэх • Ажлыг зохион байгуулахад удирлагын зүгээс зөв оновчтой арга зүйгээр ханган ажилласнаар тухайн ажил үр дүнтэй. • Сургууль хамт олон нэг баг болж ажиллаж чадвал ямар үр дүнд хүрч болохыг энэ төсөл харууллаа
Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс	<ul style="list-style-type: none"> • Мэдээллийг товч тодорхой үр дүнтэй мэдээллийг хүргэх • Мэдээллийн зөв хэрэгслийг сонгон ашиглах • Төсөв, санхүүг шууд ил гаргах байх • Зорилтод бүлгийнхээ хүмүүс мэдээллийг хүргэх
Холбоо барих хаяг, лого:	<p style="text-align: center;">Сонгинохайрхан дүүрэг, 1-р хороолол, 13 дугаар хороо, Залуус-1 “Хөгжил” цогцолбор сургууль</p> <p>Захирал С.Энх-Ариун гар утас: 91913846, 88013393 Цахим хаяг: Enkhariun0909@gmail.com Нийгмийн ажилтан Б.Мөнхтулга гар утас: 99837849 Цахим хаяг: tulga.baatarjav@gmail.com</p>





**НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ "ИРЭЭДҮЙ"
ЦОГЦОЛБОР СУРГУУЛЬ**



“Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хэрэгжилт манай сургуульд



Г.Цагаанцоож (Нийслэлийн ерөнхий лаборатори цогцолбор захирал): **(Нийслэлийн боловсролын Ирээдүй сургуулийн**


Ирээдүй цогцолбор сургууль 2021 оноос энэхүү төсөлд хамрагдаж бидний хувьд шийдэж чадахгүй хүнд байсан Ахлах сургуулийнхаа дээврийн засварын ажлыг 153,9 сая төгрөгөөр хийлгэж дууслаа. Цас, борооны үеэр дээврээс ус гоожих, нэвтрэх, улмаар чийг авч

удахаараа мөөгөнцөр үүсэх гээд хүндрэлтэй асуудал байлаа.

Сургалтын орчинд болон сурах үйлд муугаар нөлөөлсөн, хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд суралцах эрх зөрчигдөж байсан энэхүү асуудлыг бүрэн шийдсэндээ манай хамт олон баяртай байна.

Дээврийн засварын ажлыг “Хөлөг-Од” ХХК гүйцэтгэж, хугацаандаа хүлээлгэн өглөө. Манай хамт олон энэхүү төслийг хэрэгжүүлэх явцдаа хяналт тавих зорилго бүхий эцэг эхийн оролцоотой “Дэмжих баг”-ыг захирлын тушаалаар байгуулж, сургалт, зөвлөгөө өгч, хуваарь гарган ажилласан. Энэхүү “Дэмжих баг”-аа ХАБЭА-ын шаардлагын үүднээс малгай, бээлий, нүдний шил, өмсөх хувцсаар ханган, “Дээврийн засвар” гэсэн групп чатыг нээн өдөр бүр мэдээлэл солилцон хяналт тавьж ажилласан. Үүний үр дүнд сургуулийн дээврийн засварын ажлын эхлэл, явц, үр дүн нь бүх хүмүүст нээлттэй ил тод явагдсан тул чанартай сайн гүйцэтгэсэн гэдэгт итгэлтэй байна.

Манай сургуулийн сургалтын орчны хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэж өгсөн Төслийн багийн хамт олондоо баярлаж байгаагаа илэрхийлж ажлын АМЖИЛТ хүсье.



Ү.Наранчимэг (Нягтлан бодогч):

Дээврийн засвар хийгдээгүй байхад 2 давхрын дотор талын таазнаас шохой унаж дусаал гоожиж ангиуд болон нийтийн эзэмшлийн талбайд бороо орох үед ус тосдог хүндрэлтэй байдалд байсан. Засвар хийгдэх явцыг байнга ажиглаж хяналт тавьж байх хугацаанд илэрсэн зөрчлийг Дэмжих багийн гишүүдтэйгээ цахимаар холбогдож арилгуулж байсан бөгөөд гүйцэтгэгч “Хөлөг-Од” компанитай хамтран

ажиллаж ХАБЭА-ын нэг бүрийн хэрэгслийг тогтмол ашиглаж байсан бөгөөд “Хөлөг-Од”

компанийн ажилчдад мөн шаардлага тавьж аюулгүй байдлыг хангуулан ажилласны үр дүнд ямар нэгэн аваар осол гараагүй манай дээврийн засварын ажил амжилттай хийгдэж дууссан.

С.Батмөнх (сургуулийн цахилгаанчин)

Төслийн хүрээнд хийгдэж байгаа ажилд цахилгаанчны болон ХАБЭА-ын ажилтны хувиар дэмжин оролцлоо. Дээврийн засварыг эхлэхээс дуусах хүртэл ажлын явцад хяналт тавьж цахилгааны тэжээл уртасгагч бусад тоноглолыг бүрэн угсарч өгч ажиллах орчныг бүрдүүлэн хамтран ажиллалаа. Дээврийн засварыг чанарын болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллуулахын тулд өдөр бүр хяналт тавьж зааварчилгааг өгч ажилласан. Цахимаар дэмжих багийн групп нээж ажлын явцыг зурагжуулан, илтгэх хуудас боловсруулан байршуулж мөн ХАБЭА-ын нэг бүрийн хувцас өмсөж дээвэр дээр гарахад аюулгүй талаасаа зүгээр байсан.



Б.Энхчимэг (Ирээдүй цогцолбор сургуулийн эцэг эхийн төлөөлөл)

Улсын тэргүүний лаборатори Ирээдүй цогцолбор сургуульд манай 2 хүүхэд суралцдаг. Манай хүүхдүүд улсын сайн сургуульд суралцаж байгаад маш их баярладаг ээж хүний хувьд хүүхдийнхээ сурч боловсорч байгаа сургуулийг өнгө үзэмжтэй, халуун дулаан, эрүүл, эрсдэлгүй сайн сайхан байгаасай гэж санаа зовниж байдаг. Сургуулийн Дэмжих багийн гишүүн болж байгууллагын багш,

ажилчидтай санал бодлоо солилцож ажиглах хуудасны дагуу бага, дунд, ахлах сургуулийн гадаад, дотоод орчинтой нарийн танилцаж явахад ахлах сургуулийн дээврээс дусаал гоожоод маш хүндрэлтэй байгаа харагдсан, мөн хогийг ангилан ялгаагүй, сантехник элэгдэж муудсан байдалтай байсан. Барилгын дээврийн засварын ажилд хяналт тавих хугацаанд өөрийн гэртээ засвар хийлгэж байгаа юм шиг сайхан санагдсан одоо ахлах сургуулийн дээврээс дусаал гоожихгүй мөн хогийг ангилан ялгах боломжтой болсонд маш их баярлаж байна. Та бүгдийн ажилд өндрөөс өндөр амжилтыг хүсье.

Сурагчдыг сурч боловсроход таатай сургалтын эко орчин бүрдүүлэх

Зорилго	Багш, ажилчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлж мөн сурагчдын сурч боловсроход таатай эрүүл аюулгүй эко орчин бүрдүүлэх
Нөхцөл байдал тулгамдсан асуудал	<ul style="list-style-type: none"> ➢ Ахлах сургуулийн дээврийн хар цаас хуйларч дусаал гоожиж сургуулийн анги, танхим, нийтийн эзэмшлийн талбай, цайны газар, багшийн хөгжлийн өрөөний тааз руу нэвтэрч мөөгөнцөр үүссэн. ➢ Сургуулийн гадна хогийн сав дээгүүрээ онгорхой, хогийг ангилан ялгаагүй. ➢ Сургуулийн сантехник хуучирч, элэгдэж, муудсан.
Зорилтот бүлэг	235 багш, ажилтан албан хаагч, 4315 суралцагч, 4500 гаруй эцэг эх
Шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> ➢ Анги кабинетын ширээ сандал хүүхдийн нуруунд тохирч буй эсэх ➢ Цонх, хаалга, шатны аюулгүй, бүрэн бүтэн байдал ➢ Мэдээллийн технологийн кабинетын тогийн аюулгүй ажиллагаа ➢ Спорт заалны шал стандартын эсэх ➢ Номын сангийн номын тавиурын бүрэн бүтэн байдал стандартын эсэх ➢ Номын сангийн номын шороо тоос цэвэрлэгээ ➢ Анги, кабинетын эд хөрөнгийн эвдрэл, гэмтэл, цэвэрлэгээ тохижилт ➢ Ариун цэврийн байгууламжийн цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал халдваргүйтэлд, эвдрэл ➢ Дотор хяналтын камерын хамрах хүрээ, хүчин чадал, түүний ажиллагаа ➢ Сургуулийн нийтийн эзэмшлийн талбайд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх хяналтын хуудас ➢ Сургуулийн барилгын аюулгүй байдлын хяналтын хуудас ➢ Дээврээс дусаал гоождог эсэх ➢ Дотор цахилгааны монтаж ➢ Сургуулийн хашааны бүрэн бүтэн байдал, эвдрэлтэй эсэх ➢ Сургуулийн орчны цардсан зам, талбай бүрэн бүтэн байдал ➢ Гадна гэрэлтүүлэг ➢ Хөгжлийн бэрхшээлтэй (Тэргэнцэртэй) сурагч орох гарахад зориулагдсан зам ➢ Цахилгааны утас, цахилгааны шийтийн бүрэн бүтэн байдал цоожтой эсэх ➢ Гадаад орчны цэвэрлэгээ, хогийн сав хогийг ангилсан эсэх ➢ Сургууль орчны хүүхэд унаж бэртэх эрсдэлтэй онгорхой траншейны таг, худаг нүх ➢ Сургуулийн гадна зүлэгжүүлэлт бут сөөг тарьсан модны арчилгаа хамгаалалт ➢ Авто замын тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч

БИДНИЙ ТУРШЛАГА-2021

	<ul style="list-style-type: none"> ➤ Сургууль орчны барилга угсралтын ажил, унаж бэртэхээс сэргийлсэн тэмдэг, тэмдэглэгээ ➤ Сургуулийн сантехникийн ажиглалтын хуудас ➤ Сургуулийн подвалын ажиглалтын хуудас ➤ Covid-19 Корона вирусээс сэргийлсэн зөвлөмж, зөвлөгөө тэмдэг тэмдэглэгээ байгаа эсэх
<p style="text-align: center;">Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Эцэг эх, багш, ажилтан, удирдлагын төлөөллөөс бүрдсэн “ДЭМЖИХ БАГ”-ийг 13 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. ➤ “Дэмжих баг”-ийн хийх ажлын жагсаалтыг гаргаж төлөвлөгөө боловсрууллаа. ➤ “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх” нь төслийн сургалтад хамрагдаж арга зүйн зөвлөгөө мэдээлэл авсан. ➤ багийн ахлагч Г.Эрдэнэбулган, гишүүд П.Хоролням, Ү.Наранчимэг нар хамтран сургуулийн 235 багш ажилтан албан хаагч болон эцэг эхийн төлөөлөл 110 эцэг эхэд сургалт явуулж уг сургалтад “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх ” нь төслийг танилцуулж Үр дүнгийн тогтвортой байдал, Сайн засаглал – Нийгмийн хариуцлага, эцэг эхийн оролцоонд суурилсан хяналт шинжилгээ үнэлгээний ойлголт гэсэн сэдвээр 5-р сарын 17, 18-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгууллаа. ➤ Бага, дунд, ахлах сургуулийн хичээлийн 4 байранд гадаад, дотоод орчны аюулгүй байдалд эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ хийх хяналтын хуудсыг ерөнхий боловсролын сургуулийн MNS: 6782:2019 стандартын дагуу 26 чиглэлээр хяналтын хуудсыг боловсруулсан . ➤ “Дэмжих баг”-ийн гишүүд сургуулийн гадна, дотор орчинд ажиглалт хийж хяналт, шинжилгээ үнэлгээ хийх хуудасны дагуу дүгнэж сургуулийн орчинд эрсдэлтэй зүйлсийн жагсаалтыг гаргасан. ➤ Сургуулийн орчинд сурагчдын сурч боловсроход эрсдэлтэй байгаа болон сайжруулах шаардлагатай байгаа зүйлсийн жагсаалтыг гаргаж эцэг, эхэд танилцуулж асуудлыг шийдвэрлэх, дотоод нөөц бололцоогоо ашиглах, боломжийг эрэлхийлж хамтран ажилласан.
<p style="text-align: center;">Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Бага, дунд, ахлах сургуулийн гадна хогийн савыг дээгүүрээ ил задгай байсныг дээгүүрээ битүү болгож, хогийг хуванцар, цаас, лааз гэсэн ангиллаар ялган хийх боломжтой болгон засаж сайжруулсан. ➤ 2021-2022 оны хичээлийн жилийг угтаж ахлах, дунд, бага сургуулийн гадна үүдний хэсгийн өнгө үзэмжийг сайжруулж засварлалаа. ➤ Номын сангийн таазыг эмульсээр, ханыг будаж, ханын самбарыг загвар дизайныг гаргаж эсгийгээр хийсэн.

БИДНИЙ ТУРШЛАГА-2021

	<ul style="list-style-type: none"> ➤ Багш хөгжлийн өрөөний дүүжин таазыг борооны дусаал гоожиж муудсан байсныг шинэчилж нийт 500 гаруй гипсэн хавтанг шинээр хийж засварласан. ➤ Цайны газрын тааз дусаал гоожиж муудсан байсныг дүүжин таазаар шинэчилж зассан. ➤ 2 давхрын коридорт эко орчин бүрдүүлэх зорилгоор тохижуулан загасны аквариумыг шинэчилж, шинээр цэцгүүд суулгаж, шинээр 3 ширээ, Бест буйдангаас захиалж 6 ширхэг буйдан, 2 сандал байршуулж багш, сурагчдын хичээлийн бус цагаар суух таатай орчин бүрдүүллээ.
<p style="text-align: center;">Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Сургуулийн дотоод журамд сургуулийн эд хөрөнгийг багш, сурагчид хайрлан хамгаалж засан сайжруулах гэсэн заалтыг тусгасан. ➤ Эрүүл мэнд, биологийн багш нар сурагчдаар сургуулийн эко буланд байгаа цэцэг, ургамлуудыг тогтмол арчилж байх хуваарь гаргасан. ➤ Сургуулийн дотоод дүрэм, журамд ангилан ялгах хогийн савыг хэрхэн ашиглах, хогийн гарцыг багасгах, эрүүл аюулгүй цэвэр, орчин бүрдүүлэхэд хүлээх үүрэг хариуцлагын тухай тусгасан.
<p style="text-align: center;">Тулгарсан бэрхшээл, эрсдэл</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Тохижилтын ажил хийхэд зориулагдсан төсөв хүрэлцдэггүй, санхүүгийн асуудлыг хамт олны хүч, дотоод нөөц бололцоо, эцэг эхийн ажил мэргэжлийг ашиглах шаардлага тулгарсан. ➤ Байгаль, цаг агаарын бэрхшээл ажил жигд явагдахад бэрхшээл үүсгэж байлаа. ➤ Цар тахлын нөхцөл байдлын улмаас материалын үнэ өссөн байсан.
<p style="text-align: center;">Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Сургуулийн удирдлагын чиглүүлэг, дэмжлэг туслалцаа сайн байсан. ➤ Эцэг эхчүүд аливаа зүйлүүдэд идэвх санаачилгатай байж сэтгэл зүтгэл гарган сургуультай маш сайн хамтран ажилласан. ➤ Сургуулийн ажилчдын гарын ур, ажлыг хийе, бүтээе гэсэн сэтгэлээр хандаж маш их дэмжлэг болсон.
<p style="text-align: center;">Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Барилгын стандартын талаар тодорхой мэдлэг мэдээлэлтэй байх. Мэргэжлийн хүмүүсээс заавар, зөвлөгөө сургалт авах. ➤ Сургуулийн орчинд мөрдөгдөж буй дүрэм журмыг судалж сурагчдыг эрсдэлээс хамгаалах холбогдох байгууллагатай хамтран ажиллах. ➤ Цаашид эцэг эхийн оролцоог нэмэгдүүлж аливаа хүндрэл бэрхшээлтэй зарим зүйлүүдийг эцэг эхчүүдтэй хамтран шийдвэрлэх.

**АХЛАХ СУРГУУЛИЙН БАРИЛГЫН ДЭЭВРИЙН ЗАСВАРЫН АЖИЛД ХЯНАЛТ,
ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТУРШЛАГА.**

Зорилго	Ахлах сургуулийн барилгын дээврийн засварын ажилд эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт шинжилгээ үнэлгээ хийж хамтран ажиллах.
Нөхцөл байдал тулгамдсан асуудал	<ul style="list-style-type: none"> ➤ Манай сургуулийн барилга баригдаад 30 гаруй жил болсон өмнө нь ахлах сургууль дээврийн засварын ажил хийгдэж байсан боловч муу хийгдсэн учраас дээврийн хар цаас хуйларч, хагарч завсраар нь борооны ус, цасны хайлсан ус нэвтэрч анги танхим, нийтийн эзэмшил, өрөөнүүдийн таазнаас дусаал гоожиж шавар нь хуйларч, мөөгөнцөр үүссэн байдалтай байсан. ➤ Барилгын дээврийн засварын ажил хийгдэж байхад бороо орсны улмаас ажил хугацаандаа багтахгүй хойшилж байсан. ➤ Барилгын дээврийн засварыг гүйцэтгэгч “Хөлөг-Од” компани нь шинэ технологи ашиглаж байсан тул судлах бэрхшээл тулгарсан.
Зорилтот бүлэг	235 багш, ажилтан албан хаагч, 4315 суралцагч, 4500 гаруй эцэг эх.
Шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> ➤ Гүйцэтгэгч компани ХАБЭА-н шаардлагыг хангаж ажиллах ➤ Барилгын ажил явагдаж байхад сургуулийн ойр орчимд тэмдэг тэмдэглэгээ байршуулах ➤ Дэмжих багийн гишүүд хуваарийн дагуу ХАБЭА-н нэг бүрийн хэрэгслийг ашиглан хяналт тавьж хяналтын хуудсыг бөглөж илэрсэн зөрчлийг тухай бүрд нь арилгуулах. ➤ Гүйцэтгэгч компани дээврийн засварын ажлыг чанартай, технологийн дагуу бүрэн гүйцэт хийж гүйцэтгэх. ➤ “Хөлөг-Од” компани нь сургуулийн дээврийн засварын ажлын явцад хяналт тавьж ажиллах үүрэг бүхий эцэг эхийн оролцоот “Дэмжих баг”-ийн гишүүдийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана. ➤ Сургуулийн барилга байгууламж, эд хогшил, хашаа хайс, бут сөөг ногоон байгууламжийг гэмтээхгүй аюулгүйн зурвас тууз татаж ажиллана. ➤ Ажлын явцтай танилцах үед 2 талын төлөөлөл харилцан бие биетэйгээ ойлголцож тайлбар зөвлөгөө, шаардлагыг биелүүлэн ажиллана. ➤ Дээврийн засвар ажлыг хийх явцад дээвэр дээрх цахилгааны болон интернэт холбооны кабелийг тасалж гэмтээхгүй байх.
	<ul style="list-style-type: none"> ➤ Дээврийн засварын ажилд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх хяналтын хуудас боловсруулж бэлтгэсэн. ➤ Дэмжих багийн гишүүд хяналт тавихад ХАБЭА-н нэг бүрийн хэрэгслийг бэлтгэж байршуулсан. ➤ дээврийн засварын ажил 6-р сарын 23-аас эхэлж байгаатай холбогдуулан 6-р сарын 23-аас 8-р сарын 1-ний хооронд Эцэг

<p>Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат</p>	<p>эхийн оролцоот “Дэмжих баг”-ийн гишүүдийг дээврийн засварын ажил үргэлжлэх хугацаанд хяналт, шинжилгээ үнэлгээний хуудас ашиглан тогтмол хяналт тавихаар хуваарь гаргасан.</p> <ul style="list-style-type: none"> ➤ “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх ” нь төслийн санхүүжилтээр “Хөлөг-Од” компани нь Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори “Ирээдүй” цогцолбор сургуулийн барилгын дээврийн их засварын ажлыг гүйцэтгэж эхэлж байгаа бөгөөд Эцэг эхийн оролцоон дээр суурилсан сургуулийн “Дэмжих баг”-ийн гишүүдтэй “Хөлөг-Од” компани нь 2021 оны 6-р сарын 22-ны өдөр хуралдаж эцэг эхийн оролцоот, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, санал дүгнэлттэй танилцлаа. ➤ “Дэмжих баг”-ийн гишүүдийн тайланд туссан дараах зүйлсийг гүйцэтгэгч “Хөлөг-Од” компани нь барилгын дээврийн засварын ажил хийх явцад анхаарч, хэрэгжүүлэн ажиллахаар харилцан зөвшилцөж зөвшилцлийн хуудас боловсруулж ажиллалаа.
<p>Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Аюулгүй байдлыг ханган ажиллахад ХАБЭА-н инженерийн хамтаар хяналт тавин ажилласнаар барилгын ажилтнууд 100 хувь хамгаалах хувцас хэрэглэлээ бүрэн өмсөж хэвшсэн. ➤ Дэмжих багийн групп чатыг ажиллуулснаар тухай бүрд болж буй барилгын ажлыг мэдээлж илэрсэн зөрчлийг хурдан шуурхай арилгуулж байсан. ➤ Барилгын дээврийн засварын ажил хийгдэж дуусах үеэр сургуулийн дотор талын багш хөгжлийн өрөө, цайны газар гэх мэт зарим засварын ажлыг хийх боломж бүрдсэн.
<p>Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Сургуулийн дотоод орчин болон сургалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлаа бодит судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн, тоо баримтаар баталгаажуулж шийдвэрлэх арга замыг багаараа эрэлхийлэх ажлыг эхлүүлж байна ➤ Сургуулийн орчинд эрсдэлийн үнэлгээ хийж буй хяналтын комиссын гишүүдэд барилгын стандартын талаарх ойлголтыг эцэг эхийн оролцоотой өгч эцэг эхчүүдээс дэмжлэг авч ажиллана. ➤ Сургуулийн дотоод дүрэм, журамд ангилан ялгах хогийн савыг хэрхэн ашиглах, хогийн гарцыг багасгах, эрүүл аюулгүй цэвэр, орчин бүрдүүлэхэд хүлээх үүрэг хариуцлагын тухай тусгасан.
<p>Тулгарсан бэрхшээл, эрсдэл</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Барилгын дээврийн засварын ажилд хяналт тавих мөн хяналтын хуудас боловсруулахад барилгын дээврийн стандарт мөн технологийн мэдлэг ойлголт “Дэмжих баг”-ийн гишүүдэд тутмаг байсан учир бэрхшээл тулгарсан

БИДНИЙ ТУРШЛАГА-2021

	<ul style="list-style-type: none"> ➤ Сурагчдын амралтаар дээврийн засварын ажил хийгдсэн тул хуваарийн дагуу хяналт тавихад зарим эцэг эх хөдөө орон нутаг руу явсан байсан учир хотод байгаа эцэг эхтэй хуваарь солих асуудал гарч байсан.
<p style="text-align: center;">Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Сургуулийн удирдлагын чиглүүлэг, дэмжлэг туслалцаа сайн байсан. ➤ Дэмжих багийн групп чатыг ажиллуулснаар тухай бүрд болж буй барилгын ажлыг мэдээлж илэрсэн зөрчлийг хурдан шуурхай арилгуулж байсан. ➤ “Хөлөг-Од” компанитай хамтран ажиллахад ямар нэгэн бэрхшээл байгаагүй асуудлыг хамтран шийдвэрлэж дээврийн засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.
<p style="text-align: center;">Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Барилгын стандартын талаар тодорхой мэдлэг мэдээлэлтэй байх. Мэргэжлийн хүмүүсээс заавар, зөвлөгөө сургалт авах. ➤ Сургуулийн орчинд мөрдөгдөж буй дүрэм журмыг судалж сурагчдыг эрсдэлээс хамгаалах холбогдох байгууллагатай хамтран ажиллах. ➤ Цаашид эцэг эхийн оролцоог нэмэгдүүлж аливаа хүндрэл бэрхшээлтэй зарим зүйлүүдийг эцэг эхчүүдтэй хамтран шийдвэрлэх
<p style="text-align: center;">Холбоо барих хаяг, лого:</p>	<p>Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүрэг 1-р хороолол 15-р хороо Ирээдүй цогцолбор сургууль Утас: 70285054, 70185054</p> <p>Сургуулийн захирал: Г.Цагаанцоож утас: 99193269</p>

“Дэмжих баг”-ийн тушаал



НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
ЛАБОРАТОРИ ИРЭЭДҮЙ ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Хяналтын комисс байгуулах
тухай

Монгол улсын Бага, дунд боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн
20.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь төсөл”-өөр хийгдэх ахлах сургуулийн дээврийн засварын ажилд хяналт тавьж, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд хамтран ажиллах дэмжих багийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталж, байгуулсугай


2. Сургуулийн гадаад, дотоод орчны эрүүл, аюулгүй байдалд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид хийгдэх ажлын төлөвлөгөө боловсруулан танилцуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг дэмжих багийн ахлагч Дотоод хяналтын менежер Г.Эрдэнэбулган-д даалгасугай

3. Сургуулийн гадаад, дотоод орчинд 2021 оны 05 сарын 20-ны дотор эрсдлийн үнэлгээ хийж, танилцуулахыг дэмжих багийн гишүүдэд үүрэг болгосугай

ЗАХИРАЛ



Г.ЦАГААНЦООЖ



Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори “Ирээдүй”
цогцолбор сургуулийн Захирлын 2021 оны 05 сарын 10-ны
өдрийн А/19 дүгээр тушаалын хавсралт

Хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх дэмжих
багийн бүрэлдэхүүн

Ахлагч:
Гишүүд:

1. Г.Эрдэнэбулган - Дотоод хяналтын менежер
2. Я.Цэцэгээ - Сургалтын менежер
3. Б.Эрдэнэбат - Ахлах сургуулийн нийгмийн ажилтан
4. С.Дорждулам - Дунд сургуулийн нийгмийн ажилтан
5. Ж.Цэвээнжалбуу - Бага сургуулийн нийгмийн ажилтан
6. Ү.Наранчимэг - Тооцооны нягтлан бодогч
7. П.Хоролням - Сургуулийн нярав
8. Б.Дайрий - Нийгмийн ухааны багш
9. С.Цэцэгмаа - Химийн багш
10. Б.Энхчимэг - 11г ангийн сурагч Н.Сэр-Одын эзж
11. М.Уранжаргал - 11г ангийн сурагч Б.Тамирын эзж
12. Ц.Оюунчимэг - 10г ангийн сурагч
13. Ц.Анужин - 10в ангийн сурагч

Зөвшилцлийн хуудас

2021 оны 06-р сарын 24

“Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх” нь төслийн санхүүжилтээр “Хөлөг-Од” компани нь Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори “Ирээдүй” цогцолбор сургуулийн барилгын дээврийн их засварын ажлыг гүйцэтгэж эхэлж байгаа бөгөөд Эцэг эхийн оролцоон дээр суурилсан сургуулийн “Дэмжих баг”-ийн гишүүдтэй “Хөлөг-Од” компани нь 2021 оны 6-р сарын 22-ны өдөр хуралдаж эцэг эхийн оролцоот, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, санал дүгнэлттэй танилцлав.

“Дэмжих баг”-ийн гишүүдийн тайланд туссан дараах зүйлсийг гүйцэтгэгч “Хөлөг-Од” компани нь барилгын дээврийн засварын ажил хийх явцад анхаарч, хэрэгжүүлэн ажиллахаар харилцан зөвшилцлөө.

1. “Хөлөг-Од” компани нь сургуулийн дээврийн засварын ажлын явцад хяналт тавьж ажиллах үүрэг бүхий эцэг эхийн оролцоот “Дэмжих баг”-ийн гишүүдийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
2. Сургуулийн барилга байгууламж, эд хогшил, хашаа хайс, бут сөөг ногоон байгууламжийг гэмтээхгүй аюулгүйн зурвас тууз татаж ажиллана.
3. Ажлын явцтай танилцах үед 2 талын төлөөлөл харилцан бие биеэнтэйгээ ойлголцож тайлбар зөвлөгөө, шаардлагыг биелүүлэн ажиллана.
4. Сургуулийн дээврийн засварын ажлыг тендерийн материалд тусгагдсаны дагуу 100%-ийн гүйцэтгэлтэйгээр “Хөлөг-Од” компани нь чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн хүлээлгэж өгнө.
5. “Хөлөг-Од” компани нь сургуулийн дээврийн засварыг хийх явцад орчны аюулгүй байдлыг ханган ажиллах ба ХАБЗА-н хууль дүрмийг мөрдөж ажиллана.
6. Дээврийн засвар ажлыг хийх явцад дээвэр дээрх цахилгааны болон интернэт холбооны кабелийг таслаж гэмтээхгүй байх.
7. Цахилгааны хэрэглээг тоолуураар тооцох
8. Сургуулийн зүгээс ус, хүчдэл болон бусад ажиллах орчныг бүрдүүлнэ.

Захиалагч байгууллагыг төлөөлж:

Захирал: Г.Цагаанцож

“Дэмжих баг”-ийн ахлагч: Г.Эрдэнэбулган

Гүйцэтгэгч байгууллагыг төлөөлж:

Гүйцэтгэх захирал: Д.Од

Талбайн инженер: Г.Авгаанмаам

Дэмжих баг, барилгын ажлын хяналтын явцын фото зураг





НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 42 ДУГААР СУРГУУЛЬ

Тус сургууль нь 1969-1970 оны хичээлийн жилд толгойтын дэнж дээр 1-4-р ангийн 4 бүлэг 131 сурагч, 4 багш, 3 ажилтантай дан байшинд нээгдэж хичээллэж байсан. 1973-1974 оны хичээлийн жилээс 8-н жилийн дунд сургууль, 1979-1980 оны хичээлийн жилээс 10 жилийн дунд сургууль болон өргөжсөн бөгөөд эдүгээ 83 багш, захиргаа аж ахуйн 26 ажилчид, 1-12-р ангийн 2169 суралцагчтай нийт 56 бүлэг 2 ээлжээр хичээл сургалт хүмүүжлийн ажлаа явуулж байна. Нийт багш нарын 30 хувь нь Тэргүүлэх, 67 хувь нь Заах аргач мэргэжлийн зэрэгтэй. Одоогоор нийт 131 багш ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.

Тус сургуулийн зөвлөлөөс багш болон суралцагчдын сургалт хүмүүжил, авьяас чадварыг хөгжүүлэх тал дээр нарийвчлан судалсан төлөвлөгөөний дагуу ажилласнаар улс, дүүрэг, нийслэлийн хэмжээний тэмцээн уралдаан, олимпиад, урлаг, спортын уралдаан тэмцээнд тогтмол өндөр амжилт гарган оролцдог.

БИДНИЙ ЭРСДЭЛГҮЙ ЭРҮҮЛ ОРЧИН

Зорилго	Сургуулийн бага ангийн сурагчдын хичээлдээ цуглах, тарах орчныг таатай болгох, хүүхэд байгальтай зүй зохистой харьцах, байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалах үзлийг төлөвшүүлэх зорилго бүхий орчныг бүрдүүлэх ,тавих хяналт, оролцоог нэмэгдүүлэх
Нөхцөл байдал, тулгамдсан асуудал	<ul style="list-style-type: none"> • Бага сургуулийн гадна талбай хагарсан , талбайн хэмжээ бага сурагчид цуглах ,тоглоход орчин таатай бус • Сургуулийн урд болон баруун талын зам руу холбогдсон явган зам шороон зам эвдэрсэн, усанд идэгдсэн ховил ихтэй • Сургуулийн дотор байгалийн булан хийх ажлыг эхлүүлсэн боловч хөрөнгө мөнгө байхгүй байсан. • Сургуулийн төв болон бага сургуулийн хаалга хуучирсан • Гадна талбайд эцэг эхчүүд хүүхдээ хүлээн суух сандал орчин дутмаг
Зорилтот бүлэг	<ul style="list-style-type: none"> • 68 бүлгийн 2500 суралцагч, 125 багш, ажилтан, ажилчид
Шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> • Гадна талбайн өмнөх болон дараах зургийн харьцуулалт • Эцэг эхийн сэтгэл ханамжийн судалгаа,бичсэн болон илэрхийлсэн сэтгэгдэл • Сургуулийн гадна орчин дахь хүүхдийн зорчих хэсгийн хэмжээ (хэмжих нэгж метр квадратаар) бага анги • Байгалийн булангийн бүтээн байгуулалт, орчин бүрдүүлэлт
Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат	<ul style="list-style-type: none"> • Дэмжих багийн гишүүдийг оролцуулан уулзалт зохион байгуулсан. • Хяналтын хуудас ашиглан сургуулийн гадаад хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн. • Сургуулийн орчин дахь хүүхдийн зорчих хэсгийн болон сурагчдын цугларах орчны аюулгүй байдлыг бууруулах , сургуулийн орчинд байгальтай харилцах, байгалиа хамгаалах, хайрлах хүмүүжил олгох зорилгоор байгалийн булан байгуулах нь хамгийн тулгамдаж байгаа асуудлууд гэж дэмжих багийнхан үзэж, үнэлгээний үр дүндээ тулгуурлан төлөвлөгөө боловсруулсан. • Дэмжлэгийн баг"-ийн эцэг эхийн төлөөлөл сургуулийн нийт эцэг эхчүүдэд хандсан уриалга гаргасан. • Уриалгаа сургууль болон ангийн группт байршуулан эцэг эхчүүддээ хамруулах сурталчилгааны ажил зохион байгуулсан • Хандиваар хийгдэж буй ажлыг алхам тутам бүрд тайлан мэдээ гаргаж ажлын үйл явцыг зурагжуулан мэдээлж байлаа. • Хандиваар 18 сая гаруй төгрөг цугласан тул 4 төрлийн ажлыг хийж гүйцэтгэлээ. • Сургуулийн гадна болон бусад засварын ажлыг ажилчдынхаа хүчээр хийж гүйцэтгэлээ.

<p>Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд</p>	<ul style="list-style-type: none"> • Эцэг эхийн өөрсдийн нь саналаар дэвшүүлсэн ажил тул эцэг эхчүүд хүүхдийн таатай орчин бүрдүүлэхэд маш сайн хандсан. • Эцэг эхийн санаачилгаар хийсэн ажлыг нийтэд ил тод хийвэл эцэг эхчүүдийн оролцоо маш сайн байдаг юм байна. • Эцэг эхчүүдийн дэмжлэгийн хандив 18 сая төгрөг цугласан нь төлөвлөснөөс илүү олон ажил хийж амжлаа. Хийсэн ажил болон гарсан үр дүнг дурдвал: <ul style="list-style-type: none"> • Бага сургуулийн гадна талбайг квм талбайг өнгөт хавтангаар хийж эцэг эхчүүдэд хүүхдээ хүлээн амрах зориулалттай 8 ш сандал байршуулав. • Бага сургуулийг хаягжуулах болон хаалга, сургуулийн төв хаалгыг металл вакум болгон солив. • Сургуулийн дотор байгалийн буланд усан оргилуур, загасны аквариум байрлуулан загас тэжээх болон бусад тохижилтууд хийлээ. • Явган хүний зам хийх материал нөөцөлсөн. • Сургуулийн нийт эцэг эхчүүдэд ажлын тайланг талархлын брошюр хэлбэрээр хийн илгээв.
<p>Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд</p>	<ul style="list-style-type: none"> • Сургуулийн тулгамдаж буй асуудлаа бодит судалгаа, хяналт үнэлгээний үр дүн, тоо баримтаар баталгаажуулж багаар хамтран ажиллах, шийдвэрлэх боломжтойг ойлгож ажил хэрэг болгон ажиллалаа. • Дэмжих багийн гишүүд сургуулийн гадаад, дотоод орчинд хийсэн хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд түшиглэн сургуулийн орчинд тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэх арга зүйг боловсруулан төлөвлөгөө гарган бусад багш, эцэг эхчүүдэд танилцуулан тэдний саналыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлнэ. • Эцэг эхчүүдийн өөрсдийн гарсан шийдвэрийг дэмжин ажиллах үр дүн гардгийг энэ үйл ажиллагаанаас харагдаж байна. • Цаашид сургуулийн эцэг эхийн зөвлөлийн ажлыг багийн хэлбэрээр зохион байгуулж ажиллах нь зөв юм байна.
<p>Тулгарсан бэрхшээл эрсдэл</p>	<ul style="list-style-type: none"> • “Дэмжих баг” ийн гишүүд цаг барин цугларахад эхний үед бэрхшээлтэй байсан. • Хяналт-шинжилгээ хийхэд мэдлэг чадвар дутагдаж байсан • Ковидын өндөржүүлсэн бэлэн байдлын үед багаар цуглахад бэрхшээлтэй байсан. • Эцэг эхчүүд болон багш нарыг цуглуулах боломжгүй тул ихэнх ажлаа онлайнаар зохион байгуулсан. • Эцэг эхийн өөрсдийн санаачилсан ажлыг сургуулийн багш ажилчид, эцэг эхчүүдэд нээлттэй байдлаар зохион байгуулахыг чармайн ажилласан. • Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь эцэг эхчүүдийн хувьд цоо шинэ санаачилга байсан.

БИДНИЙ ТУРШЛАГА-2021

Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> • Энэхүү амжилтад хүрэхэд багаар ажиллах чадвар их нөлөөлсөн. Багаар хамтран ажилласны үр дүнд ажлын төлөвлөгөөгөө хамтран боловсруулж, мэдлэг мэдээллээ харилцан солилцож ажиллалаа. • Багийн гишүүд, багш, ажилтан, эцэг эх, сурагчдын идэвх оролцоо, хандлага энэ төрлийн ажлыг зохион байгуулахад чухал үүрэгтэй байсан. • Эцэг эхийн оролцоо хандлагын дэмжин ажилласан ажил бүхэн үр дүнтэй сайхан биелдэг нь харагдлаа. • Энэхүү амжилт гаргахад сургуулийн захиргаа зохион байгуулж, үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн ажилчдынхаа чадвар эерэг хандлагад маш их баярлаж байна.
Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс	<ul style="list-style-type: none"> • Мэргэжлийн байгууллагын заавар зөвлөгөөг авч ажиллах • Дэмжих багийн гишүүд болон багш ажилтан, эцэг эх, сурагчдыг чадавхжуулах, мэдлэг олгох үйл ажиллагааг зохион байгуулах • Эцэг эх, багш, сурагчдаас гарсан санал, дэмжлэгт • тулгуурлан ажиллах • Сурагчдад “Байгалийн булан” ийн усан оргилуурын чимээ, загасны өсөлт хөгжилт хооллолт, байгалийн орчин нь таатай эко орчинд бүрдүүлэн алжаал тайлах, амрах, орчинтой болсон нь таатай байгаа. • Дэмжлэгийн багт мэргэжлийн эцэг эхчүүдийг татан оролцуулах хэрэгтэй юм байна.
Холбоо барих хаяг, лого:	Захирал Ц. Даваадоо, Утас: 99099546, davaadoots64@gmail.com Сургалтын менежер Б. Буянхшиг, Утас: 89401290, buyankhishig1210@gmail.com

БАРИЛГЫН ИХ ЗАСВАР, ДУЛААЛГЫН ЯВЦАД ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООТ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУРШЛАГА

Зорилго	Сургуулийн их засвар, дулаалгын ажлыг чанартай хийж гүйцэтгэхэд эцэг эхийн оролцоотой хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх
Нөхцөл байдал, тулгамдсан асуудал	<ul style="list-style-type: none"> • Барилгын суурь хөгцөрч муудсан, мөөгөнцөртсөн. • Барилгын гадна талын хананд завсар гарч цуурсан, тоосго нь унасан. • Дотор талын анги танхимын агааржуулалтын нүх бөглөрсөн. • Барилгын нийт 232 цонхны түгжээ муудаж , жийрэг резин нь элэгдсэн. • Хананд цууралт өгч зарим газар тоосго нь унасан. • Аваарын хаалганы гадна талын саравч эвдэрсэн. • Сургуулийн барилгын дээвэрт 2 дугаар байранд 20 жилийн өмнө засвар хийгдсэн, 3 дугаар байранд

БИДНИЙ ТУРШЛАГА-2021

	<p>дээврийн засвар огт хийгдээгүй, дээврийн хар цаас хуучирч муудсан учир борооны ус гоождог.</p> <ul style="list-style-type: none"> • Урсгал засварын төсөв бага учраас дээврийг зөвхөн нөхөх төдий л засвар хийдэг байсан. • Барилгын ханын дулаалга муудсан, цонх хаалга • стандартын дагуу сууриглагдаагүй цанталт, дулаан • алдагдал ихтэй. • Баруун , зүүн талын аваарын хаалганы саравч эвдэрч муудсан. • Аваарын шат стандарт биш огцом , хүүхдийн хөл шатны гишгүүрийн завсраар орох эрсдэлтэй • Ус зайлуулах систем, хоолой буруу хийгдсэнээс барилгын сууринд хөгц мөөгөнцөр үүссэн.
Зорилтот бүлэг	<ul style="list-style-type: none"> • 68 бүлгийн 2500 суралцагч, 125 багш, ажилтан, ажилчид
Шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> • Дээврийн ажлын гүйцэтгэлийн хувь • Цонх солих ажлын гүйцэтгэлийн хувь • Суурийн дулаалгын гүйцэтгэлийн хувь • Гүйцэтгэгч компанийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг • ханган ажилласан ажилтны тоо • Барилгын ажлын гүйцэтгэл, хувиар
Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат	<p>Эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах байдлаар барилгын засварын ажлын явцад хийлээ.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Дээврийн засварыг зургийн дагуу гуравны нэгийг хийхэд хяналт тавьж ажилласан. • 27 цонхны амлагааг суллаж, цонх суулгах бэлтгэл ажлыг хангах, цонх суулгасан, дотор амлагаа хийж дуусаагүй. • Цонхыг суурилуулахдаа интернэтийн утас, кабелийг таслахгүйгээр хийх, суурийн дулаалгын ажилд хяналт тавьж ажилласан. • Хичээлийн 2 байрны гадна фасадын хөөс болон өнгөлгөөний шавар хийгдсэн. • Барилгын ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдлыг • ханган ажиллах талаарх талбайн ХАБ-ын инженерт болон ажилтнуудад анхаарч ажилласан • Засварын ажил 10 дугаар сарын 1-ээс эхэлсэн дараа хавар хийж дуусна.
Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд	<ul style="list-style-type: none"> • Аюулгүй байдлыг ханган ажиллахад ХАБ-ын инженерийн хамтаар хяналт тавин ажилласнаар барилгын ажилтнууд хувь хамгаалах хувцас хэрэглэлээ бүрэн өмсөж хэвшсэн. • Ажил эхлэхийн өмнөх цэвэрлэгээний ажлыг хийж, засварын ажил 20- 30 хувь хийгдсэн. • 27 цонхыг стандартын дагуу суурилуулсан, 10 цонхны амлагаа хийгдсэн.

	<ul style="list-style-type: none"> Барилгын ажлын явцад эрүүл аюулгүй байдлыг ханган ажиллахын зэрэгцээ санамж, анхааруулах тэмдэг тэмдэглэгээг хэрэглэж сурсан.
Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд	<ul style="list-style-type: none"> Барилгын дээвэр, цонх, хаалга, фасадын чанарт хяналт тавьж шалгах ажлыг сургуулийн мужаан, цахилгаанчин, слесарийн ажлын байрны тодорхойлолтод нэмэлтээр оруулж өгөхөөр ажиллаж байна. Сургуулийн их, бага засварын явцад хяналтын хуудас боловсруулан хяналт- шинжилгээ үнэлгээ хийх үйл явцыг хэвшил болгон ажиллахад анхаарч байна. Эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээгээр сургуулийн материаллаг орчныг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн.
Тулгарсан бэрхшээл	<ul style="list-style-type: none"> Барилгын материалын үнэ нэмэгдсэн шалтгаалан тендер нэлээд хойшилсон тул засварын ажил 10 сарын 1-ээс эхэлсэн ажлын явц 20-30 хувьтай хийгдсэн. Цаг агаарын эрсдэлт байдал, хөрөнгө оруулалт саатсанаар хугацаа алдаж, барилгын засварын ажил удаашрахад нөлөөлж байсан. Барилгын ажил гүйцэтгэх компанийн ажилтнууд цаг баримталж хэвшээгүй нь ихээхэн бэрхшээл болж байсан. Дэмжих багийн гишүүдийн идэвх оролцоо харилцан адилгүй байсан нь үйл ажиллагаанд бэрхшээл болж тулгамдаж байсан. Хичээллэж байгаа үед засварын ажил хийгдэж байгаа нь сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулахад бэрхшээлтэй байлаа.
Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> Арга зүйн зөвлөмж “дэмжих баг”-ийн гишүүдэд гол гарын авлага, үндсэн чиглүүлэг болсон. Зөвлөх баг болон хяналтын инженерийн үүрэг оролцоо энэ төрлийн үйл ажиллагааг зохион байгуулахад ихээхэн дэмжлэг болсон. Зөвлөх багийн зүгээс өгсөн зөвлөгөө нь тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэхэд ихээхэн ач холбогдолтой байлаа. Гүйцэтгэгч компанитайгаа хамтран ажиллаж, зөвшилцөн эерэг харилцаа үүсгэн ажиллаж байсан нь амжилтад нөлөөлж байна
Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс	<ul style="list-style-type: none"> Дэмжих багийн гишүүдийн хүлээх үүрэг, хариуцлагыг маш тодорхой болгох Дэмжих баг ажиллах хуваарь гарган, гишүүдийн ажиллах боломжийг уян хатан байдлаар зохицуулах Хийсэн ажлаа бусад сургууль цэцэрлэгт түгээн дэлгэрүүлсэн.

БИДНИЙ ТУРШЛАГА-2021

	<ul style="list-style-type: none">Барилгын их засвар, дулаалгыг хэрхэн хийдэг талаар дэмжих багийн гишүүд нэгдсэн нэг ойлголттой болох
Холбоо барих хаяг, лого:	Захирал Ц. Даваадоо, Утас: 99099546, davaadoots64@gmail.com Сургалтын менежер Б. Буянхишиг, Утас: 89401290, buyankhishig1210@gmail.com

Дэмжих багийн санаачлан хэрэгжүүлсэн ажлын фото зургийн цомог





НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН

107 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ



БИДНИЙ ТУХАЙ

СХД-ийн 107 дугаар цэцэрлэг нь 1986 оны 07 дугаар сарын 03-ны өдөр Октябрийн районы 1 дүгээр хороололд 36 багш, ажилтантай байгуулагдаж 45 хоногтойгоос 07 хүртэл насны 280 хүүхдийг хүлээн авч үйл ажиллагаагаа эхлүүлж байсан түүхтэй. Өдгөө 36 дахь жилдээ 43 багш ажилтан, 426 хүүхэдтэй сургалт үйл ажиллагаа явуулж байна. Нийслэлийн тэргүүний сургууль, цэцэрлэг шалгаруулах индексийн урамшуулал олгох журмын дагуу шалгуулж 2021 оны нийслэлийн тэргүүний цэцэрлэгээр шалгарсан. Тус цэцэрлэг нь улс, нийслэл, дүүргийн чанартай уралдаан тэмцээнүүдэд удаа дараа амжилттай оролцож ирсэн.

Тус цэцэрлэгийн эрхлэгч Б.Ганхуяг нь 2013 оноос эрхлэгчээр ажиллаж байгаа ба бид хамт олныхоо амжилтаас дурдвал:

- 2011 онд шилдэг менежменттэй цэцэрлэг
- 2012 онд СХД-ийн тэргүүний цэцэрлэг
- 2013 онд Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч итгэл хүлээсэн хамт олон
- 2015 онд шилдэг тохижилттой цэцэрлэг
- 2015 онд “Хүүхдийн авьяасыг дэмжигч” байгууллага
- 2015 оны “Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээний СХД-ийн тэргүүн байр, нийслэлийн гутгаар байр

- 2017 онд “Нийслэлийн эрүүл мэндийг дэмжигч” байгууллага
- 2018 онд “Хүмүүнлэгийн үйлсийг манлайлагч” байгууллага
- 2019 онд “Хүн болох багаасаа” хүмүүжлийн аяны эерэг дадал хэвшүүлэгч цэцэрлэг
- 2019 онд төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт 98 хувиар, бүрэн хангалттай үнэлгээ авсан.
- 2020 онд “Дасгал хөдөлгөөн хийцгээе” улсын цахим уралдааны Гутгаар байр
- 2021 онд “Эрүүл мэндийн цахим гүйлт” улсын уралдааны Дэд байр тус тус эзэлсэн амжилттай хамт олон юм.

ХҮҮХДИЙН АМЖИЛТ

Хүүхдийн авьяасыг нээн илрүүлэх, хөгжүүлэх, өөртөө итгэлтэй байдлыг багаас нь төлөвшүүлэх зорилготой “Мянган жаргалан” хүүхдийн дууны улсын уралдаанд Ахлах бүлгийн-45, бэлтгэл бүлгийн 51 нийт 96 хүүхэд оролцож

- Тэргүүн байранд Бэлтгэл “Б” бүлгийн Анх-Эрдэнэ
- Дэд байранд Бэлтгэл “А” бүлгийн Анар
- Гутгаар байран Бэлтгэл “А, В” бүлгийн Амирлан, Анандбаяр
- Бэлтгэл бүлгийн “Мөнгөн жигүүр” хамтлаг алтан медаль
- Ахлах бүлгийн “Алтан жигүүр” хамтлаг мөнгөн медаль
- Багаараа дэд байр эзэлж клип хийлгэх эрхээр шагнуулсан

МУ-ын 14 дэх аварга Хадбаатар агсанд зориулсан “Аваргын гараа” бөхийн улсын уралдаанд 2 насны ангилалд нийт 18 хүүхэд оролцож 6 хүүхэд ардын хувьсгалын 100 жилийн ойн баяр наадамд барилдах эрхээр шагнуулсан.

“Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хэрэгжилт манай цэцэрлэгт

Б.Ганхуяг (СХД-ийн 107 дугаар цэцэрлэгийн эрхлэгч)



Тус 107 дугаар цэцэрлэг нь 1986 онд байгуулагдсанаас хойш ариун цэврийн өрөөнд сангийн их засвар хийгдэж байгаагүй тул хэвтээ, босоо шугам хоолойн элэгдэл хорогдол ихтэй, далд шугамаас ус алдах эрсдэлтэй шугам хоолойг дагасан тааз хана мөөгөнцөртөх, бохир усны шугам бөглөрөх гэх мэт эрсдэл үүсэж байсан ба цэцэрлэгийн дотоод нөөц бололцоонд тулгуурлаж шугам хоолойг тухайн хэсэгт нь солих, бөглөрлийг арилгах зэрэг арга хэмжээнүүдийг авч ажиллаж ирсэн Нийслэлийн засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/169 дүгээр захирамж, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын захиалгаар “Инж байгууламж ххк” нь 2021 оны 9 дүгээр сарын 1-ээс тус цэцэрлэг дээр ирж ажиллан цэцэрлэгийн 9, 12 дугаар бүлгийн ариун цэврийн өрөөнүүдэд сантехникийн их засвар хийснээр хэвтээ болон босоо цэвэр ус, халуун усны шугамыг бүрэн солих, бохир усны шугамыг бүрэн солих, бүлгийн ариун цэврийн өрөөний тоноглолуудыг иж бүрнээр солих, бүлгийн ариун цэврийн өрөөний ханын плита,

шалны плитаг сольсноор дээр дурдсан эрсдэлүүд арилж хүүхэд тав тухтай орчинд ариун цэврийн зөв дадал хэвшлийг багаасаа эзэмших, нөхцөл бүрдэж байгаад баяртай байна.

Ц.Оюу-Эрдэнэ (СХД-ийн 107 дугаар цэцэрлэгийн арга зүйч, дэмжих багийн ахлагч)

Тус төсөл манай цэцэрлэг дээр хэрэгжиж дэмжих багийг ахалж ажилласнаар маш олон зүйлийг сурч мэдэж авсандаа баяртай байна.

Үүнд:

- Хяналт шинжилгээ үнэлгээ хийх арга зүйд суралцсан
- Хяналтын хуудас боловсруулж хэрэглэж үр дүнг тооцож төлөвлөж сурсан
- Багаар ажиллаж асуудлыг хамтран хялбар аргаар шийдвэрлэж сурсан.
- Мөн ариун цэврийн өрөөний дотоод засал чимэглэл, сангийн тоног төхөөрөмжийн чанар орц нормын талаар мэдлэгтэй болсон
- Хүүхдийн сурч хөгжих орчны стандартад нийцсэн таатай орчин
- г бүрдүүлэхэд эцэг эхчүүдийг хэрхэн татан
- оролцуулж дэмжүүлэх, үр дүнд хүргэх арга барилд суралцсан.



Б.Гончигсүрэн (СХД-ийн 107 дугаар цэцэрлэгийн багш, дэмжих багийн гишүүн)

Тус дэмжих багийн гишүүн болж ажилласнаар багаар ажиллахын давуу талыг мэдэж авсан мөн асуудлыг хялбар шийдэх, гарц гаргалгааг олж сурсан. Хяналтын хуудас боловсруулж түүний дагуу цэцэрлэгийн орчныг тохижуулах олон ажлуудыг төлөвлөн эцэг эхчүүдийн тусламжтай хийж гүйцэтгэсэнээр хүүхдийн сурч хөгжих таатай орчин бүрдсэнд багшийн хувьд дэмжих багийн гишүүний хувьд баяртай байна.

Ц.Ариунгэрэл (СХД-ийн 107 дугаар цэцэрлэгийн эцэг эхийн төлөөлөл, дэмжих багийн гишүүн)

Тус цэцэрлэгийнхээ дэмжих багийн гишүүн болж ажилласан. Хавар дэмжих багийн хурал хийж хяналтын хуудас боловсруулан цэцэрлэгийн гадаад, дотоод орчинд үнэлгээ хийж ажилласнаар цэцэрлэгийн гадаад дотоод орчинд олон ажлыг эцэг эхчүүдийн тусламжтай хийж хүүхдийн сурч хөгжих орчин сайжирсан нь дэмжих багийн гишүүд болон эцэг эхчүүдэд ил тод харагдаж байгаад сэтгэл хангалуун байна. Мөн 2 бүлгийн ариун цэврийн өрөөний сангийн засвар хийгдэж ариун цэврийн дадал хэвшлийг багаасаа суралцах тав тухтай орчин бүрдсэнд цэцэрлэгийн нийт эцэг эхчүүдийн өмнөөс баярлаж талархаж байгаагаа илэрхийлж байна.

ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ГАДААД БОЛОН ДОТООД ОРЧИНД ЭЦЭГ ЭХИЙН
ОРОЛЦОО

Зорилго	Сургуулийн өмнөх насны хүүхдийн сурч хөгжих орчин нөхцөлийг эцэг эхийн дэмжлэг, оролцоотойгоор “Эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ” хийж бүрдүүлэх
Нөхцөл байдал тулгамдсан асуудал	<p>Сургуулийн өмнөх боловсролын насны хүүхдэд сурч хөгжих сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлж өгөх нь хамгийн чухал байдаг.</p> <p>Сурах сургалтын орчныг бүрэн бүрдүүлсэн газар хүүхдүүд оюун ухаан, бие бялдар, нийгэмшихүйн талаараа цогц хөгжиж сургуулийн өмнөх боловсролыг бүрэн эзэмшдэг. “Эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ” хийх ажилд эцэг эхийг татан оролцуулахад дараах асуудлууд тулгарсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хяналт-шинжилгээ, үнэлгээний багт оруулах эцэг эхийн төлөөллийг сонгох • Төсөл хэрэгжүүлэгч байгууллагаас хүргэсэн мэдээллийг цэцэрлэгийн нийт эцэг эх, асран хамгаалагчид хүргэх • СХД-ийн 107 дугаар цэцэрлэг дээр хэрэгжиж буй төсөлд цэцэрлэгийн нийт эцэг эхийг татан оролцуулах хэрэгцээ шаардлага, асуудал, урган гарсан.
Зорилтот бүлэг	Цэцэрлэгийн 426 хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагч, 43 багш ажилтан
Шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> • 2020-2021 оны хичээлийн жилийн эхэнд цэцэрлэгийн багш, ажилтан, эцэг эхийн төлөөллөөс бүрдсэн 15 хүний бүрэлдэхүүнтэй "Дэмжих баг" байгуулж, цэцэрлэгийн гадаад орчинд эрсдэл аюулгүй байдлын хяналт үнэлгээ хийсэн байх. • Гадаад орчны эрсдэл, аюулгүй байдлын үнэлгээ, дүгнэлтэд үндэслэн цэцэрлэгийн эргэн тойронд эрсдэл, аюулгүй байдлыг 45 хувиар бууруулсан байх • Цэцэрлэгийн барилга байгууламжийн өнөөгийн байдал, засвар үйлчилгээ, дулаалгын нөхцөл байдлыг Нийслэл, дүүргийн ЗДТГ болон холбогдох байгууллагуудад танилцуулж, 2021-2022 оны хичээлийн жилд цэцэрлэгийн багш, ажилтан, эцэг эхийн "Дэмжих баг"-ийн хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг тогтмолжуулсан байх • Цэцэрлэгийн гадаад болон дотоод орчинд хийсэн хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд түшиглэн цэцэрлэгт тулгамдаад байгаа асуудлыг хэрхэн шийдвэрлэх шийдлийг дэмжих баг боловсруулсан байх
Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат	<p>Дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд дараах алхмуудыг хэрэгжүүлсэн Баг бүрдүүлэх, чадваржуулах сургалт зохиох</p> <ul style="list-style-type: none"> • 2021 онд хэрэгжих “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдлага, багш, ажилтан, эцэг эхийн зөвлөл, эцэг эх, асран хамгаалагч бүхий хүмүүсийг оролцуулан 107 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Б. Ганхуягийн тушаалаар 2021 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр “Дэмжих баг” байгуулж

	<p>комиссын даргаар тус цэцэрлэгийн Арга зүйч Ц. Оюу-Эрдэнэ томилогдож 1 нярав, 2 бүлгийн багш, 1 туслах багш, 1 сантехникч, 1 манаач, эцэг эхийн төлөөлөл болсон 8 гишүүн нийт 15 хүн ажиллахаар болж байгуулагдсан</p> <ul style="list-style-type: none"> • 2021 оны 05 дугаар сарын 21-ны өдөр Төсөл хэрэгжүүлэгч тал болох Герман Монголын хамтарсан байгууллагын А.Бүрэнжаргал, Нийслэлийн боловсролын хэлтсийн хөрөнгө оруулалтын газрын дарга Ж. Энхтөр нарын явуулсан “Эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ” сэдэвт сургалтад хамрагдаагүй дэмжих багийн бусад эцэг эхчүүдийг чадваржуулах сургалт зохион байгуулж хамруулсан. • 107 дугаар цэцэрлэгийн “Дэмжих баг”-ийн гишүүд хамтран анхны хурлаа 2021 оны 05 дугаар сарын 21-ны өдөр 15 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж цэцэрлэгийн гадаад болон дотоод орчинтой танилцан цаашид цэцэрлэгийн гадаад болон дотоод орчинд эцэг эхийн дэмжлэг оролцоотойгоор хийх шаардлагатай байгаа зүйлсийг ярилцан тодорхойлж, хяналтын хуудасны загвар боловсруулж, тохируулга хийж, цэцэрлэгийн гадаад болон дотоод орчинд үнэлгээ хийж, цаашид хийх ажлын төлөвлөгөө боловсруулсан. • Энэ төслийн хүрээнд байгуулагдсан “Дэмжих багийн гишүүдтэй харилцан зөвшилцсөний үндсэн дээр дараах тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж гаргасан. Цэцэрлэгийн гадаад талбайд хог ангилах сав байхгүй, хүүхдийн цэцэрлэгийн гадаад хашааг өндөр болгох шаардлагатай, хүүхдийн сагсан бөмбөг болон хөл бөмбөгийн талбайг стандарт шаардлагад нийцүүлэн засах санал хүсэлт гарч үүнээс нийт дэмжих багийн гишүүдийн 100% саналаар биеийн тамирын спорт талбайг бүрэн тохижуулах санал зөвшөөрөгдсөн. Мөн “Дэмжих баг”-ийн цэцэрлэгийн дотоод талбайд биеийн тамирын зааланд хүүхдийн хөдөлгөөнийг дэмжсэн төхөөрөмж хийх мөн цэцэрлэгийн коридорын паркетын шалыг хүүхдийн осол аюулгүй байдлыг хангах үүднээс өөрчилж хулдааслах шаардлагатай байна гэсэн асуудлуудыг тус тус тодорхойлж дараах тулгамдсан асуудлууд нийт цугласан дэмжих багийн 15 гишүүн 100% саналтай дэмжиж цэцэрлэгийн дотор талын шалыг хулдааслах ажлыг эхлүүлэхээр боллоо. • Цэцэрлэгийн гадаад талбайг өөрийн нөөц боломжид тулгуурлан дэмжих багийнхан болон цэцэрлэгийн ажилчидтай хамтран цэцэрлэгийн гадаад талбайд спортын талбай болон хөдөлгөөнт тоглоомын талбай, туршилтын талбайг тохижуулсан. • Цэцэрлэгийн спортын талбайд: <ul style="list-style-type: none"> • Хүүхдийн хөл бөмбөгийн талбайн хоёр талд 2 тор татсан • Сагсан бөмбөгийн талбайд БНХ-ийн стандарт хэмжээтэй хоёр талын шийд • Гар бөмбөгийн талбайд мөн цэцэрлэгийн насны хүүхдэд нийцсэн стандарт хэмжээ бүхий 1 тор хийсэн
--	--

	<ul style="list-style-type: none"> • Уртын харайлтын талбай болон хүүхдийн авиралтын шат, бусад тоглоомын өнгийг сэргээн будаж, засаж будаж өөрсдийн нөөц боломжид тулгуурлан тохижуулсан • Хүүхдийг зам тээврийн аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор цэцэрлэгийн хашааны баруун зүүн талд 50 метрт анхааруулах тэмдэг байрлуулсан. Цэцэрлэгийн хашаанд эцэг эхчүүд, хүүхдүүдэд Замын хөдөлгөөний дүрмийг танин мэдүүлэх, сурталчлах зорилготой дөрвөн замын уулзвар, тэмдэг тэмдэглэгээг сэргээн будаж, зассан. • Цэцэрлэгийн дотоод орчны нийтийн эзэмшлийн талбай болон 8 бүлэг хүүхдийн хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлсэн.
<p>Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)</p>	<ul style="list-style-type: none"> • Хүүхдүүд цэцэрлэгийн дотоод орчинд коридороор явахдаа халтирч унах осол аюулгүй болсон • Цэцэрлэгийн дотоод орчинд цэцэрлэгийн үүд болон коридор болон 3 жигүүрийн шатны доод хэсэгт • Хүүхдүүдийн хөдөлгөөн эрүүл мэндийг дэмжих спорт талбайн цогц тоглоомтой болсон / Сагасан бөмбөгийн талбай, хөл бөмбөгийн талбай, гар бөмбөгийн талбай, хөлөгт тоглоомын талбай, хөдөлгөөнт тоглоомын талбай • Цэцэрлэгийн багш ажилчид багаараа хамтран гадаад талбайд хөлөгт тоглоом болон хөдөлгөөнт тоглоомын зураг төсөл гаргаж зурж будсан
<p>Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд</p>	<ul style="list-style-type: none"> • Эцэг эх, багш ажилчдыг хамруулсан бүтээлч ажил хийсэн • Хүүхдэд ээлтэй, осол аюулгүй, хүүхдийн хөдөлгөөн эрүүл мэндийг дэмжих төв байгуулсан багш ажилчдыг шалгаруулсан • Цэцэрлэгийн дотоод журмын 7.2-т “Эцэг эхийн оролцоот хяналт, шинжилгээ-үнэлгээг жилд 2 удаа зохион байгуулна” гэсэн заалтыг оруулж өгсөн.
<p>Тулгарсан бэрхшээл</p>	<ul style="list-style-type: none"> • Дэмжих багийг ажиллуулах хүндрэлтэй байсан. Бүлэг бүрээс 1, 1 эцэг эхийг дэмжих багт оруулсан байсан нь хүндрэлтэй байсан. • Эцэг эхчүүдийн цаг зав хомс байсан тул оройн цагаар ирж үнэлгээ хийх тохиолдлууд их гарч байсан. Заримдаа дэмжих багийн эцэг эхчүүд өөрсдөө үнэлгээ хийх боломжгүй гэсэн шалтгаанаар бусад эцэг эхийг орондоо явуулж, үнэлгээ хийлгүүлж байсан нь эцэг эхчүүд чухам юу хийгээд байгаа талаар мэдээлэлгүй байх, үнэлгээг дутуу дулимаг хийх зэрэг бэрхшээл үүсч байсан. Тиймээс бүлэг бүр “дэмжих баг”-ийг байгуулж, эцэг эхийн оролцоонд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тулгамдаж буй асуудлаа илрүүлж, засан сайжруулах шаардлагатай.
<p>Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс</p>	<ul style="list-style-type: none"> • Цэцэрлэгийн гадаад болон дотоод орчны үнэлгээг хийхдээ хэрэгцээг тодорхойлон хэрэгжүүлэх, бүтээлч санал, санаачилга гарган оролцохыг эрмэлзэж байсан нь цэцэрлэгийн үйл ажиллагаа эцэг эхэд нээлттэй, ил тод болоход ихээхэн түлхэц үзүүлсэн.

	<ul style="list-style-type: none"> • Цэцэрлэгийн дэмжих баг болон төслийн баг, гүйцэтгэгч компани хоорондоо харилцан ойлголцож, бие биеэ хүндэтгэн, засах шаардлагатай зүйлийг харилцан зөвшилцсөний үндсэн дээр сайжруулж ажилласан. • Мөн барилгын их засварын талаарх сургалт, уулзалт зохион байгуулж, зөвлөгөө зөвлөмж өгч, хяналтын инженер ажиллаж байсан нь амжилтад нөлөөлсөн.
<p>Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс</p>	<ul style="list-style-type: none"> • Цэцэрлэгийн эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх нөлөөллийн ажи зохион байгуулж, давтамжийг ахиулах • Эцэг эхийн дундах цэцэрлэгийн үйл ажиллагааны талаарх ойлголтыг нэг болгох үйл ажиллагаа зохион байгуулах • Эцэг эхийн санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэр гаргахад оролцуулж, тэдний оролцоо дэмжлэг зайлшгүй шаардлагатайг ойлгуулах, нөлөөлөх, хандлагыг өөрчлөх
<p>Холбоо барих хаяг</p>	<p>Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 107 дугаар цэцэрлэг</p> <ul style="list-style-type: none"> • Эрхлэгч: Б. Ганхуяг Холбоо барих утас:99757988 ganabayas@gmail.com • Арга зүйч: Ц. Оюу-Эрдэнэ Холбоо барих утас: 80006444 oyukatsoggerel@gmail.com





НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 170 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ



Бидний тухай

Сонгинохайрхан дүүргийн 170 дугаар цэцэрлэгийн барилга 2011 онд ашиглалтад орж, сургалт хүмүүжлийн үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга 2016 онд ашиглалтад орсон бөгөөд одоо 80 багш, ажиллагсадтай, Сонгинохайрхан дүүргийн 25 дугаар хорооны 700 гаруй хүүхдийг хүлээн авч, сургуулийн өмнөх боловсролыг олгож байна.


Дэмжих багийн санаачилгаар 2021 онд тус цэцэрлэгийн гадаад талбайд нарийн ногоо тарих хүлэмжийг байгуулж, арвин ургац хураан авсан.

Мөн Дэмжих багийн гишүүд хамтран эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээндээ тулгуурлан хүүхдийн хөл бөмбөгийн талбайг шинээр барьж гүйцэтгэсэн.

САЙН ТУРШЛАГЫН БАРИМТЫН ХУУДАС

Сайн туршлагын нэр:	Цэцэрлэгийн гадаад, дотоод орчныг сайжруулах
Зорилго	Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, дүрэм, журам, СӨБ-ын орчны стандартын хэрэгжилтэд хяналт – шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг арилгах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах
Нөхцөл байдал, тулгамдсан асуудал	Цэцэрлэгийн гадна талын эрсдэл <ul style="list-style-type: none"> ✚ Тоглоомын талбайн хүртээмж нэмэгдүүлэх ✚ Бохирын цооногийг шилжүүлэх ✚ Дээврийн дулаан алдалт цас борооны ус дусах эрсдэлийг бууруулах ✚ Гадна талбайн камер ✚ Тохижилт үйл ажиллагаа Цэцэрлэгийн дотор талын эрсдэл <ul style="list-style-type: none"> ✚ Дулаан ✚ Анги тохижилт ✚ Хувцасны шүүгээ ✚ 0о-ын өрөө
Шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> - Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох нөхцөл үүссэн байдал - Цэцэрлэгийн барилгад шаардлагатай засвар, үйлчилгээ хийгдсэн байдал.
Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат	<p>2020-2021 оны хичээлийн жилд эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх төсөлт ажлын хамт олонтой хамтран ажиллалаа. Ажиллаж байх хугацаандаа хийж хэрэгжүүлэх ажлыг судлан, тодорхойлж төлөвлөгөө боловсруулан эцэг эх багш ажилчид олон нийтийн оролцоотойгоор орчин нөхцөлөө сайжруулж, төсөлд хамрагдсан сургууль цэцэрлэгээс туршлага хуримтлуулан, туршлагаа хуваалцан ажиллаа.</p> <p>Манай цэцэрлэг нь цэцэрлэгийн эцэг эхийн зөвлөл болон хамт олон дотроо хурал зохион байгуулж дэмжих багийг 15 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулсан. Дэмжих багийн ахлагчаар Арга зүйч С.Оюунсүвд ажилласан.</p>
Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)	<ul style="list-style-type: none"> - Төлөвлөгөөний дагуу ашигладаггүй, хагарч цуурсан хуучин уурын зуухны нүүрсний агуулахыг буулгаж, суурин дээр нь бэлтгэл ангийн эцэг эхийн санаачилга дэмжлэгээр хүүхдүүд зугаалгын цагаар суух, тоглох саравч байгуулсан. - Мөн буулгасан агуулахын тоосго, блокоор хогийн цэг барьж ашиглалтад оруулсан. - “Ахлах” бүлгийн эцэг эхтэй хамтран “НЭГ ХҮҮХЭД 5 ТООСГО” аян өрнүүлж цугласан тоосгоор хүлэмжийн эх биеийг босгож, эцэг эхийн дэмжлэгтэйгээр хүлэмжээ барьж өргөст хэмх тарьж намар хүүхдүүддээ танилцуулж, хүүхдийнхээ хоол хүнсэнд хэрэглэв. Мөн ажилчдадаа зах зээлийн бөөний үнээр

БИДНИЙ ТУРШЛАГА-2021

	худалдаалан олсон орлогоороо цэцэрлэгийнхээ гандсан будгыг сэргээн засварласан.
Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд	<ul style="list-style-type: none"> • Ажлын явцын мэдээг тогтмол цэцэрлэгийн ажиллагсад, эцэг эхчүүдэд танилцуулж, шаардлагатай нэмэлт тусламж, дэмжлэгийг авч ажилласан.
Тулгарсан бэрхшээл, эрсдэл:	<ul style="list-style-type: none"> • Хүлэмжийн ногоо тариалахад мэргэжлийн ажилтнуудын зөвлөгөө, туршлага хуваалцах байдал дутмаг байсан.
Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> • Эцэг эхчүүдийн дэмжлэг өндөр байсан.
Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс	<ul style="list-style-type: none"> • Сонгинохайрхан дүүргийн бусад төрийн өмчийн сургууль, цэцэрлэгүүдэд туршлагаа хуваалцах шаардлагатай.
Сайн туршлагыг илтгэх зургууд	
Холбоо барих хаяг, лого:	<p style="text-align: center;">Сонгинохайрхан дүүрэг, 25-р хороо, Зүүн салаа Эрхлэгч Д.Цэрэндулам Ажлын утас: 96002893 Гар утас: 88076237</p> 



НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 69 ДҮГЭЭР СУРГУУЛЬ



Бидний тухай

Баянзүрх дүүргийн 5-р хорооны нутаг дэвсгэрт байрладаг 69-р сургууль нь 1978 онд анх байгуулагдсан бөгөөд улмаар 8 жилийн 30 дугаар сургуультай хамтран боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөрийг дэмжиж, бүх шатны боловсролын стандартад түшиглэн сургалтын шинэлэг арга удирдлага, менежментийг боловсронгуй болгох зорилгоор хэв шинжийн өөрчлөлт хийж Нийслэлийн Засаг Даргын 1997 оны 8-р сарын 15-ны өдрийн А/104 тоот захирамжаар гүнзгийрүүлсэн сургалттай “Шавь” цогцолбор сургууль болж байсан.

“Шавь” цогцолбор сургууль нь 1997-2020 он хичээл сургалтын үйл ажиллагаагаа явуулж байгаад, Нийслэлийн Засаг Даргын 2020 оны 12-р сарын 31-ний өдрийн А/1338 тоот захирамжаар бүтцийн өөрчлөлт орж, эргээд 30, 69 дүгээр сургууль болон тусдаа бие даасан сургуулиуд болсон.

**НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 69 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН САЙН
ТУРШЛАГЫН БАРИМТЫН ХУУДАС**

<p>Сайн туршлагын нэр:</p>	<ul style="list-style-type: none"> - Ангилдаг хогийн савыг эцэг эхчүүд дэмжлэгийн багийн тусламжтайгаар сургуулийн гадаа болон, хичээлийн А,Б байруудад байршуулсан. - Цайны газрын өргөтгөлийг хийж гүйцэтгэв. - Маахуурын уулзвараас сургууль хүртэлх замын хашлага, “Анхаар хүүхэд” тэмдэг, хурд сааруулагч зэргийг холбогдох байгууллагуудад удаа дараагийн албан хүсэлт явуулсны дагуу Цагдаагийн ерөнхий газраас авто зам, явган замыг тусгаарласан хашлага, анхаар хүүхэд тэмдэг хурд сааруулагч зэргийг сургуулийн орчинд хийж өгсөн. - Дэмжлэгийн багийн дарга Б.Анхбаяр, нарийн бичиг Нармандах нар хүүхдийн эрхийн Тэмүүлэл клубийн сурагчдын хамтаар Хүүхдийн чуулга уулзалт, сурагчдын тулгамдаж байгаа асуудлуудын хэлэлцүүлэгт оролцож БЗД тамгын газрын дарга Алтанзагас сургуулийн залгаа байдаг худгийн асуудлыг танилцуулж худгийг нүүлгэн шилжүүлэх талаарх тусламж хүссэн. Тамгын газрын дарга ач холбогдол өгч тусална гэж зөвшилцөлд хүрсэн
<p>Зорилго</p>	<ul style="list-style-type: none"> • Багш, ажилтан, сурагчдыг хог ангилан хаях хэвшлийг бий болгох. • Сурагчдыг сургуульдаа зорчин ирэх замыг аюулгүй болгож, хүүхдэд ээлтэй болгох, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх. • Сургуулийн дэргэд байрладаг худаг нь хүүхэд явахад эрсдэлтэй цэг бөгөөд худгийг нүүлгэн шилжүүлэх.
<p>Нөхцөл байдал, тулгамдсан асуудал</p>	<p>Манай сургуулийн хувьд төв замд ойр байдаг хичээлийн Б байрны залгаа хойд талд худаг байдаг нь машины түгжрэл үүсгэх, иргэд худгаас ус авахдаа хогоо ил задгай хаях, бие засах, халтиргаа гулгаа үүсэх зэрэг зэрэг нь сурагчдын эрүүл аюулгүй орчинд сурах эрхийг боогдуулж байна.</p>
<p>Шалгуур үзүүлэлт</p>	<ul style="list-style-type: none"> • Эцэг эхийн оролцоот хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хяналтын хуудсаа тун няхуур, багийн гишүүдийн оролцоог ханган, харилцан ярилцаж боловсруулах • Сургууль орчинд ногоон байгууламжийн тоо м² талбайн хэмжээ нэмэгдэнэ. • Сургуулийн хойд хаалганд явган зорчигч зорчиход дэмжлэг үзүүлэх • Маахуурын уулзварын замд явган зам, авто замыг тусгаарлаж өгснөөр сурагчдын сургуульдаа зорчин ирэх аюулгүй байдлыг бүрдүүлэх • Ангилдаг хогийн сав сургуульд байрлуулснаар сургууль орчны цэвэр байдлыг хангана, сурагчдыг зөв дадал хэвшилтэй болгоно,

<p>Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат</p>	<ul style="list-style-type: none"> • Дэмжих багийн гишүүдийг чадавхжуулах, багш ажилтны хууль эрх зүйн мэдлэгийг сайжруулж, хүүхдийн эрүүл аюулгүй байдлыг хангах зорилгоор “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын орчны (MNS6558:2015) стандарт”-ын мэдлэг олгох сургалтыг 3 зохион зохион байгуулсан байгуулсан. Уг сургалтад нийт 15 дэмжих багийн гишүүд оролцсон • Сургуулийн гадна орчинд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүднээс гишүүд бодит байдалтай газар дээр нь танилцаж, мэдээлэл цуглуулан, тулгамдсан асуудлыг тодорхойлсон <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Сургуулийн хойд талын худгийг нүүлгэх • Маахуурын уулзвараас сургууль хүртэлх авто зам, явган хүний замыг тусгаарлах хайс хашлага хийх • Ангилдаг хогийн савыг байршуулах • Сургууль орчны тохижилтыг хийх хичээлийн А,Б байруудад • Сургууль орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх • Сургууль орчны цахилгааны шийт ДПС-ийг хаших, хамгаалах • Сургуулийн цайны газрыг өргөтгөх • Сургууль орчмын бүс, анхаар хүүхэд тэмдэг тэмдэглэгээг хийх • Хичээлийн Б байрны 1 давхрын цонхнуудыг торлох
<p>Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)</p>	<ul style="list-style-type: none"> • Сургууль эцэг эхчүүдийн хамтын ажиллагаа сайжирсан • Өөрсдийн дотоод нөөц боломжуудыг эрэлхийлж сургууль орчмын эрсдэлийг бууруулсан.
<p>Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд</p>	<ul style="list-style-type: none"> • Дэмжих багийн гишүүд өөрийн ажил, мэргэжлийн онцлогийн дагуу “Эцэг эхийн зөвлөл”-тэй хамтран эцэг эхийн боловсролд зориулсан сургалтыг улирал бүр зохион байгуулж байна • Эцэг эхчүүдэд болон зохион байгуулагдсан ажлуудыг Сургуулийн цахим сүлжээнд мэдээллийг түгээж олон нийтэд хүргэдэг • Үр дүнг тогтворжуулахаар холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллаж байна. (БЗД-ийн Тамгын Газар, БЗД, 5-р хороо, Дэлхийн Зөн ОУБ, Goodneighbors ТББ)
<p>Тулгарсан бэрхшээл, эрсдэл:</p>	<ul style="list-style-type: none"> • Цар тахлын улмаас хил гааль хаагдаж бараа таваарын үнэ өссөн, бараа материал ирэхгүй байгаа нь дэмжлэгийн багийнхны ажлыг удаашруулж байна. • Тохижилтын ажил хийхэд зориулагдсан төсөв хүрэлцдэггүй, санхүүгийн асуудлыг хамт олны хүч, дотоод нөөц бололцоо, эцэг эхийн ажил мэргэжлийг ашиглах шаардлага тулгарч байна. • Хүйтний улирал эхэлж байгаа нь зарим ажлуудыг хойшлуулах шаардлага тулгарсан.
<p>Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс</p>	<ul style="list-style-type: none"> • Дэмжлэгийн багийн үйл ажиллагааг эцэг эхчүүдэд ойлгуулж, мэдээллийг сайн хүргэснээр эцэг эхчүүд хүүхдийн сургалтын орчинд илүү анхаарах болсон. • Эцэг эхчүүд үр хүүхдүүдийнхээ төлөө сэтгэл гаргах зөв хандлагатай болсон.

БИДНИЙ ТУРШЛАГА-2021

	<ul style="list-style-type: none"> Мэргэжлийн байгууллагууд нь төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, тулгамдаж буй асуудлыг хамтран шийдвэрлэхэд оролцсон нь амжилтад эергээр нөлөөлөв.
<p>Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс</p>	<p>Сургалтын орчныг бүрдүүлэх чиглэлээр батлагдсан хууль тогтоомж болон орчны стандартын талаар багш ажилтан, эцэг, эхэд сургалт зохион байгуулах, хийгдэж байгаа ажлын талаар оролцогч талуудад тухай бүр мэдээлж байх.</p>
<p>Сайн туршлагыг илтгэх зургууд</p>	
<p>Холбоо барих хаяг, лого:</p>	<p>БЗД-ийн 5-р хороо, 69 дүгээр сургууль 99891641, 88089026, 89370370</p>



НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН АМГАЛАН ЦОГЦОЛБОР СУРГУУЛЬ



БИДНИЙ ТУХАЙ

- Тус сургууль нь ДЗД-ын Б/89-р захирамжаар 27-р сургууль татан буугдаж боловсролын хөгжлийн бүтцийн өөрчлөлтөөр 1998 онд 8-р бага сургууль, 27-р дунд сургуулийг тус тус нэгтгэн Улаанбаатар хотын наран мандах зүгт Амгалан цогцолбор сургуулийг Баянзүрх дүүргийн 8-р хорооны нутаг дэвсгэрт байрлах 1975 онд ашиглалтад орсон, хуучнаар зөвлөлтийн цэргийн штаб байрлаж байсан байрыг сургуулийн зориулалтаар засаж, Нийслэлийн Засаг даргын захирамжийн 1998 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/129 дүгээр захирамжаар Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын “Амгалан” цогцолбор сургуулийг байгуулсан. Нийт 34 багш, 18 ажилчин, 750 сурагчидтайгаар сургалтын үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн түүхтэй.
- Одоогоор хичээлийн 3-н байртай, нийт 150 багш, ажиллагсад, 2100 сурагчтайгаар сургалтын үйл ажиллагааг явуулж байна.
- Нийт 68 бүлэгт 2100 сурагч суралцаж байна.
- Нийт 56 анги, кабинеттай, уншлагын 2 танхим бүхий номын сантай.
- Биеийн тамирын заал болон урлаг заалтай.
- 12 заах аргын секцтэй бөгөөд бүгд тусдаа ажлын өрөөтэй.
- Багш хөгжлийн төв, өдөр өнжүүлэх хүүхэд хөгжлийн төвтэй

СУРГУУЛИЙН ОНЦЛОГ:

- Физик, математикийн гүнзгийрүүлсэн сургалтай.
- 6-12р ангиудад математикийн гүнзгийрүүлсэн сургалттай
- 6,8,9-р ангиудад англи хэлний гүнзгийрүүлсэн сургалттай ангиудыг шинээр нээн ажиллуулсан.
- Байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалсан Эко сургууль боллоо.

- “Олон улсын эко сургууль” хөтөлбөр Монгол улсад хэрэгжиж буй бөгөөд манай сургууль идэвхтэй амжилттай оролцож 2017 онд Хүрэл, Мөнгөн гэрэгээ авсан
- 2017 онд “Амьтанд ээлтэй хамт олон”
- 2017 онд “Биеийн тамир спортыг дэмжигч” байгууллага
- 2018 онд Нийслэлийн хэмжээний Шилдэг 20 сургууль “Индексийн шалгаруулалт”-аар сонгогдсоны нэг нь боллоо.

ҮНДСЭН ЧИГЛЭЛ: Боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага мөн.

БАЙГУУЛЛАГЫН ЭРХЭМ ЗОРИЛГО: Монгол улсад боловсрол ноёлсон нийгэм, байгууллагад гар бие оролцон сурагчдын эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох хэрэгцээг ханган ажиллаж, нэгдмэл стратеги дээр үндэслэн нийгмийн захиалгад нийцүүлэн бодит бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэхэд оршино.

БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛТ: Суралцах чадвартай, түүх соёл, үндэсний уламжлалаа өвлөсөн, эрүүл чийрэг, хүмүүнлэг хүүхэд.



Нийслэлийн Ерөнхий боловсролын Амгалан цогцолбор сургуулийн захирал: Л.Баянтуул

Манай сургуулийн хичээлийн 1-р байрны дулаалгын их засварын ажлыг ЦАГААН ТОЛГОЙН НУУР ХХК тендерт шалгарч ажлаа хийж эхлээд байна. Ковид-19 цар тахлын улмаас тус компанийн ажил хойшлогдож 8 сард Цонх солих ажил хийгдэж

9 сард дууссан. Сургуулийн сурагчдаа эрүүл аюулгүй таатай орчинд сургах нь нэн тэргүүний ажил байдаг. Сурагчид сурч боловсрох багш, ажиллагсад ажлаа хийж гүйцэтгэхэд тулгарч байгаа нэг бэрхшээл хичээлийн байр маань хүйтэн байдаг асуудал байсан билээ. Сургуулийн орчныг сайжруулах шинэчлэн засварлаж сурч, ажиллах ая тухтай, таатай орчин нөхцөл бүрдүүлэхэд хамтран ажиллаж байгаа төслийн баг, хөрөнгө оруулагч байгууллага, дэмжих багийн гишүүд, эцэг эх, багш ажиллагсдаа баярлаж байна. Сурагчдын маань сурч хөгжих орчин таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд дан ганц сургуулийн баг хамт олон оролцохоос гадна эцэг эхчүүд оролцоод дэмжин хамтарч ажилласнаар маш олон эерэг хандлага, туршлага бий болж байна. Төслийн маань онцлог барилгын их засвар дулаалга хийгдэхээс гадна бусад оролцож байгаа хүмүүсийн хооронд нөхөрсөг харилцааг бий болгож түүний үндсэн дээр туршлага болохуйц ажлууд хийгдсэн байна.




Нийгмийн ажилтан У.Заяабаяр

Хичээлийн 1-р байранд хэрэгжиж байгаа Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь төслийн хүрээнд зохион байгуулалтад орсон Дэмжих багийн ахлагчаар ажиллаж байна. Бид нар дэмжих багаараа эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан Хяналт-шинжилгээ үнэлгээ хийх аргачлалын дагуу сургуулийн гадаад дотоод орчин болон барилгын их засварын цонх солих эхэн, дунд, сүүлийн шатанд үнэлгээ хийж зөвшилцлийн хуудсаа боловсруулж ажилласан.Энэ ажлын хүрээнд

дулаан алдалтад нөлөөлдөг хүчин зүйлийг илрүүлсэн.Цонхны ажлын явцыг өдөр тутам хянаж чанартай хийж гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллалаа.Хүүхдүүдийн сурах таатай орчин нөхцөл бүрдэж байгаад бид бүхэн туйлын их баяртай байна.


Сургуулийн багш, ажиллагсдын хүүхдүүдийн өдөр өнжүүлэх төв

Зорилго	Багш, ажиллагсдын хүүхдүүдийн чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрөөх, багшийн ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх,нийгмийн асуудлыг шийдвэрлэх
Нөхцөл байдал, тулгамдсан асуудал	<p>Багш нарт өөрсдийн хүүхдүүдээ хичээл тарсны дараа болон өмнө нь хаана байлгах вэ яах вэ гэсэн асуудлууд судалгаагаар гарч ирсэн. 2020 оны 9 сард тус сургууль нь 640 хүүхдийн суудалтай өргөтгөлийн барилгаа хүлээн авч сургалтын үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Хичээлийн 1-р байранд ахлах ангийн бүлгүүд хичээллэж сул анги танхим гарсантай холбогдуулан 2021 онд багш, ажиллагсдынхаа нийгмийн асуудлыг шийдэх ажлын хүрээнд ӨДӨР ӨНЖҮҮЛЭХ төвийг эцэг эхийн болон бусад байгууллагын дэмжлэгтэйгээр байгуулж ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> • “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хүрээнд 2021 оны сургуулийн захирлын тушаалаар дэмжих баг байгуулагдаж, барилгын их засвар болон сургуулийн гадна, дотор орчинд эцэг эхийн оролцоонд суурилсан хяналт-шинжилгээ үнэлгээ хийж эцэг эхээс санал асуулга авсны үр дүнд сайжруулах шаардлагатай зүйлсийн жагсаалтыг гаргасан.
Шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> • Багш, ажиллагсдын тулгамдсан асуудал судалгаа авсан • Өдөр өнжүүлэх төвд явах хүүхдүүдийн судалгаа • Өглөө өдөр хичээллэх хугацаа тодорхой болгох • Төсөл хэрэгжсэний өмнөх болон дараах үеийн нөхцөл байдлын
Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат	<ul style="list-style-type: none"> • Өдөр өнжүүлэх төв байгуулах ангиа сонгосон • Явах хүүхдийнхээ тоог гаргасан • Хичээл заах багш нарын хуваарь гаргасан

Нөхцөл байдал, тулгамдсан асуудал	Тус сургуулийн хогийн цэг нь дээвэр байхгүй блокоор өрсөн төмөр сараалжин хаалгатай байсан бөгөөд Намар, хаврын улиралд хашаагаар хог хийссэн байдалтай байдаг байсан. Хүүхдүүд хогийг ангилах нь байгальд ямар ээлтэй байдаг талаар мэдээлэл авдаг байсан ч сургуулийн орчинд ангилж хаяж сураагүй байсан
Шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> • Хогийн цэгийн байршлыг тодорхойлсон • Хэрэглэгдэх материалын тооцоог гаргасан • Хийх ажилтнуудаа томилсон • Ангилал хийх тооцоог гаргасан
Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат	<ul style="list-style-type: none"> • Хуучин хогийн цэгийг буулгасан • Шинэ хогийн цэгийн шалыг бетондсон • Хогийн цэг барих квадрат төмөр болон бусад хэрэглэгдэх материалуудыг тооцон худалдан авч хийж хэрэгжүүлсэн.
Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)	<ul style="list-style-type: none"> • Сурагчид хогоо ангилан хаяхдаа ангиллын 3 хэсэгтээ хаяж сурсан • Сургуулийн орчинд хог хийссэн болон бусад сөрөг асуудлууд гарахаа байсан • Хоёрдогч түүхий эдийг хурааж байгаад тушааж сургуулийн ариутгалын хэрэгсэл авахад хэрэглэж хэвшсэн. • Сургуулийн орчны цэвэрлэгээ сайжирсан • Сургуулийн гадна орчин сайжирсан
Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд	<ul style="list-style-type: none"> • Сурагчдадаа хичээл эхлэхэд сургуулийн хогийн цэг эцэг эхчүүдийн дэмжлэгтэйгээр шинээр баригдсан талаар мэдээлэл өгсөн • Дэмжих багт байгаа эцэг эхийн төлөөллүүд бусад ангийн эцэг эхийн зөвлөлийн дарга нарт хийсэн ажлын талаарх мэдээллийг хүргэж эцэг сурагчид, багш ажиллагсад нэг ойлголттой болсон.
Тулгарсан бэрхшээл, эрсдэл:	<ul style="list-style-type: none"> • Хөрөнгө санхүүгийн асуудал • Төмрийн худалдааны үнийн хөөргөдөл их байсан
Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> • Эцэг эхийн зөвлөл тусалж дэмжин хогийн цэгийн шинэчлэх ажилд 800000 төгрөгийн хандив үзүүлсэн. Дэмжих багийн 1 гишүүн дээврийн төмрийг хандиваар өгсөн гэх мэт дэмжлэгээр хийж гүйцэтгэсэн.
Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс	<ul style="list-style-type: none"> • Хөрөнгө санхүүгийн асуудал • Бүх талуудын нэгдсэн ойлголт ямар учраас үүнийг шинэчлэх болсон үнэлгээний хуудасны нэгтгэл • Талуудыг үүрэг оролцоо
Сайн туршлагыг илтгэх зургууд	

Холбоо барих хаяг, лого:	Нийслэлийн Ерөнхий Боловсролын Амгалан цогцолбор сургууль БЗД 8-р хороо УС-15 хотхон Ботаникийн эцэс Утас: 11460168
--------------------------	---

Спорт заалны шал болон хажуу талын ус тогтдог хэсгийн засвар

Зорилго	Сургуулийн сурагчид эрүүл аюулгүй орчинд суралцах
Нөхцөл байдал, тулгамдсан асуудал	Хавар, намар болон дулааны улиралд тус сургуулийн спорт заалны зүүн талд хүүхдүүд нэвтэрч ордог хэсэгт борооны ус их хэмжээгээр тогтдог байсан бөгөөд энэ нь хүүхдүүдийг хичээлдээ ороход хүндрэлтэй тойрч гардаг байсан. Мөн заалны шал болон дулааны шугам сүлжээ нь муудсан байсныг засаж сайжруулах шаардлагатай байсан.
Шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> • Ус тогтдог хэсгийн хэмжээг тодорхойлсон • Гадаргууг тэгш байлгах • Хэрэглэгдэх материалын тооцоо
Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат	<ul style="list-style-type: none"> • Спорт заалны зүүн талын хэсгийг бетондсон. • Спорт заалны шалыг лагдаж будаж засварласан • Дулааны шугам хоолойг шинэчилсэн
Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)	<ul style="list-style-type: none"> • Ус тогтохоо байсан • Заалны шал цэвэрхэн стандартын дагуу болсон • Паар болон бусад шугам сүлжээг янзалснаар дулаан алдалт болон бусад эрсдэлүүд багассан.
Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд	<ul style="list-style-type: none"> • Дэмжих багт байгаа эцэг эхийн төлөөллүүд бусад ангийн эцэг эхийн зөвлөлийн дарга нарт хийсэн ажлын талаарх мэдээллийг хүргэж эцэг сурагчид, багш ажиллагсад нэг ойлголттой болсон.
Тулгарсан бэрхшээл, эрсдэл:	<ul style="list-style-type: none"> • Хөрөнгө санхүүгийн асуудал • Цемент болон бусад хэрэглэгдэж буй зүйлсийн үнийн хөөргөдөл их байсан
Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> • Сургуулийн эрэгтэй багш, ажилчид ажиллаж хийж гүйцэтгэсэн.
Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс	<ul style="list-style-type: none"> • Хөрөнгө санхүүгийн асуудал • Бүх талуудын нэгдсэн ойлголт ямар учраас үүнийг шинэчлэх болсон үнэлгээний хуудасны нэгтгэл • Талуудыг үүрэг оролцоо
Сайн туршлагыг илтгэх зургууд	
Холбоо барих хаяг, лого:	Нийслэлийн Ерөнхий Боловсролын Амгалан цогцолбор сургууль БЗД 8-р хороо УС-15 хотхон Ботаникийн эцэс Утас: 11460168



НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН УЛСЫН ТЭРГҮҮНИЙ 122 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ



БИДНИЙ ТУХАЙ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн 122-р цэцэрлэг нь 13-р хороолол 15-р хороо, Сангийн гудамжинд байрладаг. 1989 онд 14 бүлэг 330 хүүхдийн хүчин чадалтай, 42 багш, ажилтантайгаар үйл ажиллагаагаа эхлүүлээд өнөөдрийг хүртэл 32 дахь жилдээ сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаагаа явуулж байна. Одоогоор нийт 54 багш, ажилтантай, хамран сургах тойргийн 15, 18, 26-р хорооны бага насны хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгож байна.

Манай цэцэрлэг 100 хувь мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан, багш нарын 95 хувь бакалавар, тэргүүлэх 5, заах аргач 8, нийт 18 багштай “Тоглоомын үйл ажиллагаагаар дамжуулан хүүхэд бүрийг бие, сэтгэл, оюун ухаанаар эрүүл өсөн бойжиход багш, эцэг эх дэмжигч байж, өөрийн бүтээлч үйлээрээ хөгжих боломж олгох” эрхэм зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс “Хэрэгцээ сонирхолд нь нийцсэн сургалтын орчинд хүүхдийг тоглох явцад нь хөгжүүлэх” үзэл

баримтлал дээр тулгуурлан “Сэдэвт тоглоом”-ыг сургалтын гол хэрэглэгдэхүүн болгон хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байна.

БИДНИЙ АМЖИЛТ

Он	Амжилт
1993	Нийслэлийн цэцэрлэгүүдийн “Гар бөмбөгийн аварга”
1994	“Дүүргийн тэргүүний цэцэрлэг”
2003	Нийслэлийн “Ногоон төгөл цэцэрлэг” Засаг даргын өргөмжлөл
2003	“Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”
2004	Нийслэлийн засаг даргын “Хүндэт өргөмжлөл”
2004	“Оюуныг дэмжигч байгууллага” батламж
2006	“Хөдөлмөрийн манлайлагч байгууллага” өргөмжлөл
2006	“Цэргийн баяр”-т дүүрэгт тэргүүн байр, Нийслэлд 3-р байр
2007	Нийслэлийн “2006 оны тэргүүний өмч эзэмшигч байгууллага” өргөмжлөл
2008	МЭЗСОУХ-ны “Хүүхдэд ээлтэй байгууллага” өргөмжлөл, “Монгол ёс заншил-логик сэтгэлгээний танхим” гэрчилгээ
2007	НХЦҮЭ-ийн “Тэргүүний үйлдвэрчний бүлэг” 5 аее аабааеаі
2010	Баянзүрх дүүргийн Тэргүүний цэцэрлэг
2011	Улаанбаатар хотын Тэргүүний цэцэрлэг
2013	Улсын тэргүүний цэцэрлэг
2014	Индексийн үнэлгээгээр шалгарсан
2016	Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо “Хөдөлмөрийн хүнийг дэмжигч байгууллага”
2018	Нийслэлийн боловсролын газрын “Батламж” Нийслэлийн боловсрол – Бидний туршлага мэдээллийн санд бүртгэгдэв.
2018	БСШУСЯ, Боловсролын хүрээлэнгийн “Батламж”
2019	Нийслэлийн 2019 оны Тэргүүний төрийн өмчийн цэцэрлэг
2020	Нийслэлийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар “Хүүхдэд ээлтэй байгууллага” цол

“МОНГОЛ ДАХЬ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ” ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ МАНАЙ ЦЭЦЭРЛЭГТ



Г.Мандалсүрэн (Баянзүрх дүүргийн Улсын тэргүүний 122 дугаар цэцэрлэгийн эрхлэгч):

Манай цэцэрлэг дээр 2021 онд Нийслэлийн хөрөнгө оруулалтаар дээврийн их засвар, НҮБ ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр гал тогооны ерөөний их засвар хийгдсэн. Эдгээр засварын явцад “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь “ төслийн нэг бүрэлдэхүүн болох цэцэрлэг сургуулийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоот үр дүнд

суурилсан хяналт шинжилгээ үнэлгээ хийх, нийгмийн эгэх хариуцлага, хамтын ажиллагааг бэхжүүлэх аргачлалыг хэрэгжүүлэн ажиллаж их зүйлийг суралцаж мэдэж авлаа. Урьд нь олон засвар явагдаж байхад гүйцэтгэгч компани ажлаа хийж, бид явцад ингэж хяналт тавьдаггүй байснаас засварын чанарт маш их алдаа гарч байсанд дүгнэлт хийсэн. Төслийн хүрээнд цэцэрлэгийн ажилчид болон эцэг эхийн төлөөлөл оролцсон дэмжих багийг байгуулан ажилласан нь хэдийгээр энэ жил барилгын материалын олдоц ховор байсан ч засварын ажлыг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэхэд сайнаар нөлөөлсөн. Мөн бид хяналт үнэлгээ хийх арга зүйд суралцаж энэ сайн туршлагаа үйл ажиллагаандаа хэрэгжүүлж цэцэрлэг-гэр бүлийн хамтын ажиллагааг бэхжүүлэн ажиллаж байна. Мөн бид барилга засварын талаар олон талын мэдлэг мэдээлэлтэй болсон. Бидний үйл ажиллагааг байнгын дэмжиж мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж тусалдаг төслийн багийн хамт олондоо талархал илэрхийлье.

Н.Бяцханцэцэг (Баянзүрх дүүргийн Улсын тэргүүний 122 дугаар цэцэрлэгийн арга зүйч, дэмжих багийн ахлагч):

“Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төсөлд манай цэцэрлэг хамрагдсанд маш их баяртай байна.

Барилгын талаар юу ч мэдэхгүй, яаж энэхүү төслийг хэрэгжүүлэх юм болоо л гэж бодож итгэл муутайхан эхэлж байсан. Цэцэрлэг маань жил жилд л хавар цас хайлах, бороо орох бүрт л анги танхим руу ус орж хүүхдийн сурч хөгжих үйл ажиллагаа болон багш, ажилтны ажиллах нөхцөлд хүндрэл учруулж байсан. Дэмжих багийг байгуулан хамтран ажилласнаар эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргад суралцаж, хамтран ажиллах арга барил эзэмшлээ.



Н.Уранчимэг (БЗД-ийн Улсын тэргүүний 122 дугаар цэцэрлэгийн бүлгийн багш, дэмжих багийн гишүүн)

Би цэцэрлэгийнхээ анхдагч багш нарын нэг. 34 дэх жилдээ ажиллаж байна. Манай анги 2 давхарт байрладаг. Бороо их орох үед бүлгийн анги танхим, өрөө тасалгаанууд, хонгилын таазнаас ус гоождог байсан. Энэ байдал олон жил үргэлжилсээр цэцэрлэгийн захиргаа өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан урсгал засвар хийдэг байсан ч асуудлыг шийдвэрлэж чаддаггүй байлаа. 2021 оны 4-р сард “Эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” төсөл дээврийн их засварт хамрагдах болсон. Төсөл хэрэгжихэд цэцэрлэгийн удирдлага, багш, эцэг эх, бусад ажилчдын төлөөлөл нэгдэн цэцэрлэгийн бодлого, хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийхэд “Дэмжих баг” бүрдүүлэн миний

бие энэ багийн гишүүнээр орж, чадавхжуулах шат дараатай сургалтад хамрагдан барилгын их засвар, дулаалгын талаарх мэдлэгтэй болоод зогсохгүй эцэг эхтэй хамтран хяналтын хуудас боловсруулан хамтран үнэлгээ хийж өөр хоорондоо харилцан ярилцаж, үйл ажиллагаагаа явуулдаг байсан. Төслийн үр дүнд манай анги болон дээврээс борооны ус гоожихоо больж бид бүхэн туйлын их талархаж байна. Ийм сайхан эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж өгсөн төслийн багийн хамт олонд баярлалаа. Та бүхэндээ ажлын амжилт хүсье.



Г.Түвшинбат (Баянзүрх дүүргийн 122 дугаар цэцэрлэгийн сантехникч, дэмжих багийн гишүүн)

Манай цэцэрлэгт дээврийн засварын ажил хийгдэж 2-р давхрын 6 бүлэг, баруун, зүүн жигүүрийн урьд талаас ордог 2 бүлэгт хуучин дээврийг нь бүрэн хуулж, цутгалт хийж, 2 давхар хар цаас нааж, дээврийн стандартын дагуу засварыг гүйцэтгэсэнд манай цэцэрлэгийн хамт олон, эцэг эхчүүд маш их баяртай байна.

Өмнө нь дээврийн ус гоожиж, анги, танхим, хонгилын хана, тааз болон ангиудын унтлагын өрөөнд ус тусалж, тав духгүй байсан.

Дэмжих багийн гишүүний хувиар би дээврийн их засвар гүйцэтгэгч компанийн ажилчидтай хамтран өдөр тутам ажлын явцад нь хяналт хийж ажиллаж байсан. Одоо манай цэцэрлэгийн дээврээс ус гоожихгүй, хүүхдийн болон багш, ажилчдыг эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлөөр хангасанд туйлын баяртай байна.



Ж.Билэгдэмбэрэл (Баянзүрх Улсын тэргүүний 122 дугаар цэцэрлэгийн дэмжих багийн гишүүн, “Дэгдээхэй” дунд бүлгийн П.Пунцагноровпил ээж)

Манай улсын тэргүүний 122-р цэцэрлэгт хүү, охин хоёр маань сурч хүмүүжин том нь сургуулийн сурагч болон амжилттай суралцаж байна. Энэхүү цэцэрлэг маань GEZ хөрөнгө оруулалтаар санхүүжих дээврийн их засварын ажил хийгдэн цэцэрлэгийн эцэг эхийг төлөөлөн миний бие хөндлөнгийн хянагчаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийх дэмжих багт орсон билээ.

Ажлын явц тендер ямар нэгэн асуудалгүй зөв зохион байгуулалттай явагдаж байсан нь цэцэрлэгийн удирдлага зохион байгуулалт сайтайг харуулж байсан. Хяналтын багийнхан тухай бүр очиж ажлын явцтай танилцаж байсан нь цэцэрлэгийг хүүхэд сурган хүмүүжүүлэх ажлаас гадна бусад хэчнээн их ажилд багш хамт олноороо гар бие оролцон ажилладаг болохыг ойлгосон. Цэцэрлэгийн барилгын дээврийн ус гоожихгүй байдал дулаалгын ажил амжилттай хэрэгжиж бидний бяцхан үрс минь дулаан аюулгүй дээвэртэй болсонд баяртай байна.

САЙН ТУРШЛАГЫН БАРИМТЫН ХУУДАС

Сайн туршлагын нэр:	Цэцэрлэгийн сайн засаглалыг бэхжүүлэх
Зорилго	Хүүхдийн сурах хөгжих, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэхэд цэцэрлэг-эцэг эх хамтдаа асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх
Нөхцөл байдал, тулгамдсан асуудал	<p>“Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хүрээнд 2021.04.19-ны өдрийн А/12 тоот тушаалаар “Эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” дэмжих баг байгуулсан. Дэмжих багийнхан дараах тулгамдсан асуудлыг гаргаж ирсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Камераа сайжруулах - Шалны хулдаасыг солих - Экологийн боловсролын талбайг тохижуулах - Халаалтын системийг сайжруулах - Тогооч нарын ур чадварыг дээшлүүлэх - Эцэг эхийн хандлага, зан үйлд нөлөөлөх - Аюулгүй орчин бүрдүүлэх буюу сургалтын дотор орчинд барилгын засвар хийх <p>Дээрх тулгамдсан асуудлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Бага насны хүүхдийн аюулгүй сургалтын орчин бүрдүүлэх, хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлагыг бодит амьдрал дээрх хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт үнэлгээ хийх хэрэгцээ нэмэгдсэн. - Экологийн боловсролыг олгож, цэцэрлэгийн туршилтын талбайд ургамлыг хэрхэн тарьж ургуулах тухай мэдлэг чадвар олгох буюу хүүхдэд тохирсон хөдөлмөр үйл ажиллагааг хангалттай түвшинд зохион байгуулж чаддаггүй

Шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> - Бид багш, ажилтан, эцэг эхийн төлөөллөөс оролцуулан 15 хүний бүрэлдэхүүнтэй “хамтарсан баг” байгуулж цэцэрлэгийн гадаад, дотоод орчинд эрсдэл, аюулгүй байдлын үнэлгээ хийсэн. - Цэцэрлэгийн гадаад болон дотоод орчны аюулгүй орчинд хяналт хийж, эрсдэлийг бууруулсан. - Цэцэрлэгийн гадна талбайд модны нэр, төрөл нэмэгдсэн. - Хяналт-шинжилгээ, үнэлгээнд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх
Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат	<ul style="list-style-type: none"> - Дэмжих багаараа чадваржуулах сургалтад хамрагдсан. - Дэмжих багийн гишүүдийн хяналтын хуудасны тусламжтай илрүүлсэн, цэцэрлэгийн гадаад, дотоод орчин болон ногоон байгууламжид тулгамдаж байгаа асуудлыг нэгтгэв. - Цэцэрлэгийн дотоод хяналтын багийнхантай хамтран гадаад, дотоод орчинд хяналтыг хийж засан сайжруулах ажлыг дотоод нөөц, эцэг эхийн дэмжлэгтэйгээр хийсэн. - Дэмжих багаараа тулгамдсан асуудлыг шийдвэрлэх ажлын төлөвлөгөө боловсруулсан. - Багш, ажилтныхаа дэмжлэгээр хүүхдийн танин мэдэхүйг сайжруулах үүднээс жимсний төгөл талбайд нэмэлт 4 нэр төрлийн модыг тарьсан.
Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)	<ul style="list-style-type: none"> - Хүүхэд бага наснаасаа эхлэн амьд байгальтай зохистой харьцах, хайрлах, хамгаалах, үзлийг төлөвшүүлэх, өөрийн насны онцлогт тохирсон хөдөлмөрийг хийх боломжтой, суралцах явцдаа мэдлэг эзэмших боломжтой болсон. - Цэцэрлэгийн гадаад орчинд эрсдэлийн үнэлгээг хийж үүссэн эрсдэлийг 100% арилгаж чадсан. - Цэцэрлэгийн дотоод орчинд эрсдэлийн үнэлгээг хийж үүссэн эрсдэлийг 100% арилгаж чадсан. - “Жимсний төгөл” талбайд хүүхдийг танин мэдэхүй, байгальтай танилцах боломжтой болсон төдийгүй туршилт үйл ажиллагаанд хамрагдсан. - Гадна талбайн зураглал хийсэн. - Цэцэрлэг-гэр бүлийн хамтын ажиллагаанд шинэ ахиц өөрчлөлт гарсан.
Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд	<ul style="list-style-type: none"> - Цэцэрлэгийн хашаан доторх “жимсний төгөл”-ийн талбайд өдөр тутмын зугаалгын үйл ажиллагаанд модыг танилцуулах, тэдгээрийг таних, нэрлэх, арчлах, усалж ургуулах, хайрлах, хамгаалах зэрэг зөвлөгөө өгсөн. - Цэцэрлэгийн удирдлага, багш, ажилтан, эцэг эхтэй хамтран хүүхдийн сурч хөгжих эрсдэлгүй орчин бүрдүүлэхэд хамтран ажиллах, жилд 2 удаа эрсдэлийн үнэлгээг хийв. - Цэцэрлэг-гэр бүлийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд санаачилгатай Дэмжих багт ажилласан эцэг эхээс гадна бусад эцэг эхийн идэвхийг өрнүүлэх, гэр бүлтэй хамтран ажиллах гэрээнд “ эцэг эх нь хүүхдийн сурах хөгжих орчны аюулгүй байдлын үнэлгээ хийх ажилд хичээлийн жилд

	<p>хоёроос доошгүй удаа санаачилгаараа оролцох нэмэлт заалт оруулсан.</p>
<p>Тулгарсан бэрхшээл, эрсдэл:</p>	<ul style="list-style-type: none"> - Өндөржүүлсэн бэлэн байдалтай холбогдуулан багш нар бүлгийн эцэг эхчүүдтэй биеэр уулзах боломжгүй учраас 14 бүлгийн фейсбүүк группээр дамжуулан цахим зөвлөмж, уриалгыг боловсруулан мэдээлсэн нь үр дүнтэй байсан эсэхийг тооцох боломжгүй байсан. - Санхүүгийн боломжийг бий болгох нь хүндрэлтэй байсан. - Дэмжих багийн гишүүд нь өвчлөлөөс болгоомжлон аливаа зохион байгуулагдаж буй ажилд жигд оролцохгүй байсан нь бэрхшээлтэй байсан.
<p>Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс</p>	<ul style="list-style-type: none"> - Цэцэрлэгийн гадаад болон дотоод орчны эрсдэлийн үнэлгээг тогтмолжуулан гарсан эрсдэлийг цаг хугацаанд нь засварлан хийж байсан. - Өндөржүүлсэн бэлэн байдлын үед цэцэрлэгийнхээ “122-р цэцэрлэг” болон 14 бүлгийн фейсбүүк группээр дамжуулан эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилчдад фото зургаар ажлаа танилцуулж байсан. - Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг байгууллагын ажилчдад танилцуулан, цэцэрлэгийн нөөц бололцоог ашиглан ажиллаж төлөвлөсөн ажлаа цаг хугацаанд нь дуусгаж чадсан.
<p>Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс</p>	<ul style="list-style-type: none"> - “Эцэг эх, багш, цэцэрлэгийн гурвалсан гэрээ”-нд эцэг эх, асран хамгаалагч нарын үүрэг, оролцоо, хариуцлагыг сайтар тусгаж, хамтран ажиллах төлөвлөгөөг хичээлийн жилийн эхэнд танилцуулах, тэдний саналыг сонсож хэрэгжүүлж ажиллах - Хүүхдийг эрсдэлээс хамгаалах, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай - Багш, ажилчдынхаа дунд хийгдэх ажлын талаар нэгдсэн ойлголт өгөх
<p>Сайн туршлагыг илтгэх зургууд</p>	


<p>Холбоо барих хаяг, лого:</p>	<p>Баянзүрх дүүргийн 15-р хороо, 13-р хороолол, Самбуугийн гудамж, Ц-122 Эрхлэгч Г.Мандалсүрэн, утас: 11454319, 95859226, цахим хаяг: gmandalsuren1234@gmail.com Арга зүйч Н.Бяцханцэцэг, утас 88082761, цахим хаяг: nbyatshaa@gmail.com Багш Н.Уранчимэг, утас: 99223654, цахим хаяг: uranchimeghoney@gmail.com</p>

БАРИЛГЫН ИХ ЗАСВАР, ДЭЭВРИЙН ЗАСВАРЫН ЯВЦАД ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООТ, ҮР ДУНД СУУРИЛСАН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НЬ

<p>Зорилго</p>	<p>Цэцэрлэг гэр бүлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, хүүхдийн сурч хөгжих орчны аюулгүй байдлыг хангаж сайжруулах.</p>
<p>Нөхцөл байдал, тулгамдсан асуудал</p>	<ul style="list-style-type: none"> - Цэцэрлэг нь 32 жилийн насжилттай учир чанар нь муудаж, өрөө тасалгаа, цонх цантаж дулаан алддаг. - Барилгын дээврийн хар цаас маш их нөхөөстэй, бүрэн бүтэн байдал алдагдсан, хаанаа цав гарч ус гоожиж байгаа нь мэдэгдэхгүй, завсраар нь чийг нэвчсэн. - Дээврийн хаялга төмөр хөндийрч унасан.

	<ul style="list-style-type: none"> - Бороо, цас орсон үед таазаар ус алддаг, хана дагаж анги танхим, өрөө тасалгааны тааз, хана, агааржуулалтын нүх норсон, шохой будаг нь хууларсан, бүх бүлгийн өрөө тасалгаанд хөгц мөөгөнцөр үүссэн. <p>Дээрх нөхцөл байдлаас үүдэн бага насны хүүхэд эрүүл, аюулгүй орчинд сурч хөгжих ая тухтай орчныг бүрдээгүй.</p>
Шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> - Эцэг эх, багш, ажилтнаас бүрдсэн “Дэмжих баг”-ийг байгуулж, цэцэрлэгийн дээврийн засвар болон бусад ажилд хөндлөнгийн хяналт, үнэлгээг хийх - Дээврээс ус гоожих асуудлыг бүрэн зогсоож, дээврийн засварын ажлыг чанартай гүйцэтгүүлэх - Анги танхимын хана таазыг хөгц мөөгөнцөргүй, агааржуулалт сайтай болгох - Дээврийн ус зайлуулах шугамыг стандартын дагуу шаардлага хангасан материалаар хийж гүйцэтгэх - Цэцэрлэгийн дээврийн их засварын гүйцэтгэлийн явцад эцэг эхийн зүгээс хөндлөнгийн хяналт тавьж үнэлгээ хийсэн байх
Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат	<ul style="list-style-type: none"> - Цэцэрлэгийн удирдлага, багш, ажилтан, эцэг эхийн төлөөллөөс бүрдсэн ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООТ ҮР ДҮНД СУУРИЛСАН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ “Дэмжих баг”-ийг байгуулсан. - Дэмжих багийн гишүүд чадавхжуулах сургалтад хамрагдсан. - Дээврийн засварын явцад ажлын төлөвлөгөө гарган ажилласан. - Барилгын их засварын явцын хяналтын хуудастай танилцаж дэмжих багийн гишүүд өөрийн онцлогт тохируулан хяналтын хуудас боловсруулсан. - Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн тулгарсан асуудлыг шийдвэрлэхдээ гүйцэтгэгч компанитай харилцан зөвшилцөж ажилласан. - Сар бүр хийсэн ажлын тайланг гаргаж холбогдох шатны байгууллагад тайлагнаж ажилласан.
Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)	<ul style="list-style-type: none"> - Барилгын дээврээс хурын ус гоожсоноос болж муудсан хар цаас болон бусад материалыг хуулж, дээврийн засварыг бүрэн хийж дуусгасан. - Дээврийн ус зайлуулах шугамыг стандартын шаардлага хангасан материалаар хийж гүйцэтгэсэн. - Дээврийн хаялга төмөр хөндийрч унасныг засварласан. - Цэцэрлэгийн доторх анги танхим, өрөө тасалгааны тааз, хана, агааржуулалтын нүх, шохой будаг нь хууларсан, бүх бүлгийн өрөө тасалгаанд хөгц мөөгөнцөр үүссэнийг эцэг эх, багш ажилчид хамтран засварлаж сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа хэвийн явагдах боломжийг хамтын хүчээр бүрдүүлж чадсан. - Хийж буй ажлаа бүлгүүдийн цахим группээр сурталчилж бусад эцэг эхэд эергээр нөлөөлж тэдний дэмжлэгийг авч чадсан.

<p>Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд</p>	<ul style="list-style-type: none"> - Багш, ажилчид цэцэрлэгийн гадаад, дотоод орчинд хяналт-үнэлгээг хийж ажиллах, гарсан зөрчлийг цаг алдалгүй арилгаж ажилласан. - Цэцэрлэгийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа болон хүүхдийн хөгжлийг дэмжих эрүүл аюулгүй орчин бүрдүүлэхэд цэцэрлэг-гэр бүл хамтран үр дүнтэй ажиллах байгаа талаараа буюу “Дэмжих баг” ажлын талаар 14 бүлгийн цахим групп-д байршуулсан .
<p>Тулгарсан бэрхшээл, эрсдэл:</p>	<ul style="list-style-type: none"> - Барилгын их засвар болон дээврийн талаарх мэдлэг боловсрол дутмаг байсан. - Цэцэрлэгийн удирдлага, гүйцэтгэгч компанийн хооронд бага зэргийн үл ойлголцол байсан. - Хугацаа давчуу, ковидын цар тахлын үед барилгын материалын үнэ нэмэгдсэн байсан нь бэрхшээлтэй байсан.
<p>Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс</p>	<ul style="list-style-type: none"> - Барилгын их засварын талаар дэмжих багийн гишүүдэд үе шаттайгаар чадавжуулах сургалтад хамрагдсанаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйд суралцаж мэдлэгтэй болж улмаар багийн гишүүдийн идэвх сэргэсэн. - Дээврийн их засварын явцад НБГ, НХОГ-ын хяналтын инженер хяналт тавьж байсан нь засварын ажлыг чанартай хийж гүйцэтгэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж чухал нөлөө үзүүлсэн. - Дэмжих багийн гишүүд өдөр тутам хяналт тавьж тулгамдаж байсан асуудлыг илрүүлэн, засан сайжруулж, хамтран ажиллаж байсан. - Сар бүрийн 20-нд хийсэн ажлын тайлангаа илгээж дараагийн ажилд тусган ажиллаж байсан. - Гүйцэтгэгч компанитайгаа хамтран зөвшилцөж ажиллаж байсан нь амжилтад нөлөөлсөн.
<p>Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс</p>	<ul style="list-style-type: none"> - Цэцэрлэгийн бүхий л үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагч нарын оролцоог нэмэгдүүлэх, санал бодлыг сонсох шаардлагатай.
<p>Сайн туршлагыг илтгэх зургууд</p>	

	
<p>Холбоо барих хаяг, лого:</p>	<p>Баянзүрх дүүргийн 15-р хороо, 13-р хороолол, Самбуугийн гудамж, Ц-122 Эрхлэгч Г.Мандалсүрэн, утас: 11454319, 95859226, цахим хаяг: gmandalsuren1234@gmail.com Арга зүйч Н.Бяцханцэцэг, утас 88082761, цахим хаяг: nbyatshaa@gmail.com Багш Н.Уранчимэг, утас: 99223654, цахим хаяг: uranchimeghoney@gmail.com</p>



НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 136 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ



Бидний тухай

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2010 онд 125 хүүхдийн ортой Баянзүрх дүүргийн 136 дугаар цэцэрлэг ашиглалтад орж, үйл ажиллагаагаа эхэлсэн. Манай цэцэрлэг Баянзүрх дүүргийн 6 дугаар хороонд байрладаг бөгөөд 26 багш, ажиллагсадтай, жил бүр 250 гаруй хүүхдийг хүлээн авч сургуулийн өмнөх боловсролыг олгож байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд цэцэрлэгийн барилгыг чанарын өндөр түвшинд шинэчлэн засварласанд цэцэрлэгийн багш, ажиллагсад, эцэг эх, хүүхдүүд туйлын баяртай, сэтгэл хангалуун байна.

БИДНИЙ ТУРШЛАГА-2021

Сайн туршлагын нэр:	Бага насны хүүхэд сурч хөгжих монгол наадгай төсөлт тоглоомоор дамжуулан цахимаар хөгжүүлэх нь
Зорилго	Ковид-19 цар тахлын нөхцөл байдалд тохируулан “Бага насны хүүхдийг гэр бүлийн орчинд Монгол ардын уламжлалт тоглоом наадгайгаар хөгжүүлэх
Нөхцөл байдал, тулгамдсан асуудал	<ul style="list-style-type: none"> • Хорио тогтоож , хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломжгүй болсон. • Цахим хэлбэрээр зохион байгуулагдаж байгаа сургалтад хүүхдүүд, тэгш хамрагдаж чадахгүй хүндрэл гарсан. • Бүлгийн багш нарт хүүхэд бүрийг зайнаас хөгжүүлэх арга зүйн дутагдсан. • Сургалтын хэрэглэгдэхүүнийг гэр бүлийн нөхцөлд гэр бүлийн нөхцөлд ховор байсан.
Шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> • Сургалтад хамрагдах хүүхдийн тоо нэмэгдсэн. • Тоглоомоор дамжуулан зохион байгуулсан сургалтад хамрагдах хүүхдийн тоо • Тоглоомын төрөл, тоглох аргачлал олон хувилбартай болно. • Хяналт, шинжилгээ, үнэлгээнд оролцсон эцэг эхийн тоо • Цэцэрлэгийн төсөлт тоглоомын үйл ажиллагаанд хамрагдсан эцэг эхийн оролцоо, хамрагдалтын тоо
Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат	<ul style="list-style-type: none"> • Дэмжих багийн гишүүдийн хяналтын хуудасны тусламжтай илрүүлсэн,сургалтын хөтөлбөрт, монгол уламжлалын талаар цаг байгааг тодорхойлон, эцэг эхчүүдийн төлөөлөл, монгол наадгайг хүүхэд заах сургах асуудлыг дэвшүүлсэн. • Дэмжих баг, ЗАН-ын нэгдэлтэй хамтран сургалтын хөтөлбөрийн агуулгад, шинэчлэх талаар төлөвлөгөө боловсруулсан. • Монгол тоглоом, наадгайн талаар судалгаа шинжилгээ хийж, бага насны хүүхдийн насны онцлогт тоглоомын судалгаа хийсэн. • “Монгол наадгай” төсөлт тоглоомын санааг, цэцэрлэгтээ авч хэрэгжүүлэхээр зохиогчоос нь зөвшөөрөл авсан. • Монгол наадгай багц тоглоомыг бүлгүүд насны онцлогт тохируулан бүлгүүдэд хавиаргасан • Бүлгүүд хүүхдэд хүртээмжтэй байдлаар олшруулан бэлтгэсэн • Тоглох аргачлалыг тараах материал болон, цахим хэлбэрээр бэлтгэж, эцэг эх, хүүхдэд хүргэсэн. • Багш ажилчид баг болон хуваагдаж, бүлэгт дутагдаж байгаа, зарим ардын тоглоомуудыг хийж баяжуулсан. • Бүлгийн багш нар 2-3 төрлийн тоглоомыг олшруулан, эцэг эхчүүдэд тараасан.
Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)	<ul style="list-style-type: none"> • Сургалтын хөтөлбөрт монгол наадгай төсөлт тоглоомыг хөтөлбөртэй болсон. • Хүүхдийн хөгжилд гэр бүл насанд хүрэгчдийн оролцоо нэмэгдсэн. • Сургалтын үйл ажиллагааг ардын уламжлалт тоглоомоор дамжуулан хөгжүүлэх боломжийг амжилттай туршсан.

	<ul style="list-style-type: none"> • Айл, гэр бүл ардын уламжлалт тоглоомын санаатай болсон • Цэцэрлэг ардын уламжлалт тоглоомын сангаа баяжуулж, ирсэн тоглоомуудыг нэмж хөтөлбөртөө оруулсан.
<p>Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд</p>	<ul style="list-style-type: none"> • Цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрт ардын уламжлалт ёс заншил, тоглоом наадгайгаар дамжуулан хөгжүүлэх төсөлт ажлыг улирлаар зорин байгуулахаар тусгаж хэрэгжүүлж эхэлсэн. • Цэцэрлэгийн дотоод журам, ажилчдын албан тушаалын тодорхойлолтод ардын уламжлалт тоглоом наадгайг судлах, сурах, хүүхэд, гэр бүлд зааж сургах талаарх заалтыг нэмэлтээр оруулж өгсөн. • Төсөлт ажлыг амжилттай хэрэгжүүлэхэд, эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Эцэг эхтэй байгуулах” гурвалсан гэрээнд тусгасан. • Ардын уламжлалт тоглоом оор дамжуулан хөгжүүлсэн болон хийсэн ажлын үр дүнг тайлагнах өдөртэй болсон. • Төсөлт ажлын хүрээн хийсэн сайн туршлага болгон баримтжуулж, бусдад түгээн дэлгэрүүлэх ажлыг цэцэрлэгийн ажлын төлөвлөгөөнд тусгасан.
<p>Тулгарсан бэрхшээл, эрсдэл:</p>	<ul style="list-style-type: none"> • Ардын уламжлалт тоглоом наадгай хүрэлцээ хангамж муу, залуу гэр бүлүүд цаад захын шагай ч байхгүй байсан нь хүндрэлтэй байсан. • Цар тахлын үе байсан учир хүмүүсийг олноор цуглуулж, мэдээлэл өгөх , бэлтгэсэн гарын авлагаа тараахад бэрхшээлтэй байсан.
<p>Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс</p>	<ul style="list-style-type: none"> • Багш нар, эцэг эхэд байнгын дэмжлэг туслалцааг цахимаар дамжуулан үзүүлж, мэдээ, мэдээллээр хангаж удирдан чиглүүлсэн. • Өндөржүүлсэн бэлэн байдлын үед багш нар бүлгийнхээ групп хуудас, болон БЗД 136 дугаар цэцэрлэг page хуудсаар дамжуулан эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилчдад фото зураг болон бичлэг хэлбэрээр хүргэж, өөрсдийн хийж, хэрэгжүүлж буй ажлаа тахилцуулж байсан. • Ардын уламжлалт тоглоом наадгайгаар тоглох сургах аргачлалыг сургалт, үйл ажиллагааны төлөвлөлт хийж, бичлэг, аргачлалын сантай болсон.
<p>Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс</p>	<ul style="list-style-type: none"> • Ардын уламжлалт тоглоом, наадгай тоглоход баримтлах ёс заншил, тоглох дэг журмыг судлах, хүүхдэд хялбар арга зүйг судлах • Эцэг эхчүүд, гэр бүлүүдийг ардын тоглоомын наадгайгаар тоглодог мэддэг болгох зорилгоор сургалт, сурталчилгаа зохион байгуулах шаардлагатай.

Сайн туршлагыг
илтгэх зургууд



Холбоо барих хаяг,
лого:

**Баянзүрх дүүрэг 13 дугаар хороолол 6-р хороо Сангийн
хорооны гудамж Ц136**
Эрхлэгч Б. Эрдэнэчимэг Ажлын утас: 76100136
Гар утас: 99051705
Цахим хаяг: Kindergarden_136edub.edu.mn,
kindergarden136@gmail.com



**НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
50 ДУГААР ДУНД СУРГУУЛЬ**



БИДНИЙ ТУХАЙ

Нэрт соён гэгээрүүлэгч, орчуулагч, зохиолч, яруу найрагч М.Цэдэндоржийн нэрээр овоглосон Чингэлтэй дүүргийн Хошой тэргүүний 50 дугаар сургууль. Манай сургууль 1972 онд байгуулагдсанаас хойш 49 дахь жилдээ сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулж байна. 1990 онд 10 жилийн сургалттай болж өргөжин 1992 оноос гадаад хэлний гүнзгийрүүлсэн, 1994 оноос урлагийн мэргэжлийн сургалт, 1999 оноос математикийн гүнзгийрүүлсэн сургалт, 2011 оноос СЭЗДС-ийн дэргэдэх лицей ангийг нээн хичээллүүлсэн. 2019 онд төсвийн хөрөнгө оруулалтаар 450 хүүхдийн суудалтай өргөтгөлийн барилга ашиглалтад орсноор суралцагчдын анги танхимын хүрэлцээ сайжирсан.

Бид хүүхэд нэг бүрийн хүсэл тэмүүллийн төлөө уриа аюулгүй сургууль, эко сургууль, сайн сургууль, цахим сургууль, нээлттэй сургууль болох зорилго тавин ажиллаж байна.

Манай хамт олон Чингэлтэй дүүргийн тэргүүний сургуулиар 2 удаа, Нийслэлийн ТОП 10 сургуулийн нэг, боловсролын чанарын шинэчлэлийг хэрэгжүүлж, хүүхэд бүрийн бодит чадварыг хөгжүүлэн, багш сурагчдын ажиллах таатай орчныг бүрдүүлэн сургалтын чанар үр дүнгээрээ нийслэлд 4 удаа шалгарсан амжилт гаргасан.

<i>Сайн туршлагын нэр:</i>	Эцэг эхийн оролцоонд түшиглэн барилгын их засвар, дулаалгын явц дахь хяналт-шинжилгээ, үнэлгээ
<i>Зорилго</i>	Нийт суралцагчид, багш ажиллагсдын эрүүл, аюулгүй, тохь тухтай, дулаан орчинд боловсрол эзэмших, өөрийгөө хөгжүүлэх, тав тухтай, эрүүл орчинд ажиллах боломжийг бүрдүүлэх
<i>Нөхцөл байдал, тулгамдсан асуудал</i>	Сургуулийн спорт заалны дээврийн хар цаас муудсанаас шалтгаалж бороо болон цасны хайлсан ус нэвтэрч гоождог. Энэ байдлаас үүдэж цахилгааны монтажинд гэмтэл цохиулах эрсдэл үүссэн. Ариун цэврийн өрөө болон үйлчлэгч нарын өрөө, 3 давхрын агуулахад мөөгөнцөр үүссэн. Агуулахад хадгалж байсан хөрөнгийн чанарт муугаар нөлөөлсөн. Спорт заалны таазыг шохойдсон ч удалгүй ховхорч унадаг. Спорт заалны дээврийн усны хаялга эвдэрсэн. Хар цаас хөндийрч салхинд ховхрох нөхцөл бүрдсэн.
<i>Шалгуур үзүүлэлт</i>	Спорт заалны дээврийн хар цаасыг сүүлийн үеийн технологи болох тусгаарлагчаар солих Борооны усны нэвчилт, дусаал гоожилт зогссон байх
<i>Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат</i>	Эцэг эхийн төлөөллөөс бүрдсэн дэмжих баг "Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь" төслийн зөвлөх инженерийн сургалтад хамрагдаж барилгын дулаалга, стандарт, материалын онцлогийн талаар ойлголт, мэдлэгтэй болсон. Төслийн багаас барилгын дулаалга, засвар үйлчилгээний явцад хөндлөнгийн хяналт үнэлгээ хийхээр боловсруулсан "Хяналтын хуудас"-ыг ашиглан засварын ажлын эхэн, дунд, эцсийн үнэлгээ хийлээ. Үнэлгээний үр дүнд тулгуурлан зөвшилцлийн хуудас боловсруулан, гүйцэтгэгч компанидаа шаардлага тавин ажилласны зэрэгцээ төслийн баг, сургуулийн удирдлагад тухай бүрд нь тайлан боловсруулан илгээсэн. Засварын ажил дууссан дараа тайланг бичиж төслийн баг, нийслэлийн боловсролын газарт илгээсэн.
<i>Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)</i>	Спорт заалны дээврийн ажил бүрэн дууссан гэж байгаа хэдий ч комисс хүлээж аваагүй байна. Материалын хангалт, ажиллах хүчний хангалтгүй байдлаас шалтгаалан засварын ажил удааширсан. 9 сарын 4-5-ны өдрүүдэд орсон борооноор их хэмжээний борооны ус 3 давхрын ариун цэврийн өрөө, агуулах руу нэвчсэн. Дээрх байдлыг гүйцэтгэгч аж ахуйн нэгжид уламжилсан. Дээрх байдлаас шалтгаалан 3 давхрын ариун цэврийн өрөөний цахилгааны монтажийг засварлаж чадахгүй байна. Энэ бүгдийг 9 дүгээр сарын илтгэх хуудсандаа дурдсан. Дэмжих багаас дээврийн засварыг чанаргүй гүйцэтгэсэн гэж дүгнэж байна.
<i>Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд</i>	Эцэг эхийн зөвлөл, дэмжих баг сургуулийн орчны стандарт, аюулгүй байдалд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг багш, ажилтан, эцэг эхчүүдэд танилцуулсан. Спорт заалны дээврийн засварын явцад хөндлөнгийн хяналт хийж ажилласан.

	<p>Эцэг эхийн оролцоот хяналт-шинжилгээ, үнэлгээ нь сургуулийн үйл ажиллагааг сайжруулахад үр өгөөжөө өгч байгаа учир жилдээ 2 удаа “Эцэг эхийн оролцоот хяналт-шинжилгээ, үнэлгээ”-г хийж, түүний дагуу төлөвлөгөө боловсруулан хүүхдэд ээлтэй, таатай сургалтын орчин бүрдүүлэх, хүүхдийн хөгжил, төлөвшилд хувь нэмэр оруулах зорилгоор сургуулийн дотоод журам болон гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна.</p>
<p><i>Тулгарсан бэрхшээл, эрсдэл:</i></p>	<p>Сургуулийн үйл ажиллагаа дахь эцэг эхийн оролцоо бага, хамтын ажиллагааны мэдлэг ойлголт харилцан адилгүй байсан нь багагүй бэрхшээл үүсгэсэн.</p> <p>Эцэг эхийн мэдлэг боловсрол харилцан адилгүй, өмнө нь бодлого эрх зүйн баримт бичгийн өөрчлөлт, төлөвлөлтийн үйл явцад оролцож үзээгүй учир удирдах ажилтны амыг харах, санал бодлоо илэн далангүй солилцож чадахгүй, хуулиар хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагаа хангалттай түвшинд сайн мэдэхгүй</p> <p>Засварын ажил гүйцэтгэх байгууллага хүн хүч, материалын нөөцгүй байснаас шалтгаалан засварын ажил удаан хугацаагаар зогссон.</p> <p>3 давхрын ариун цэврийн өрөө, агуулахын дээд талаас борооны ус нэвтрэх байдал зогсоогүй.</p>
<p><i>Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс</i></p>	<p>Сургуулийн зүгээс:</p> <p>Энэ ажлыг хэрэгжүүлэх явцдаа эцэг эхийн оролцоот хяналт-шинжилгээ, үнэлгээний аргыг ашиглаж сурсан бөгөөд аль болох бусад үйл ажиллагаатай уялдаж, зохицуулахыг хичээн ажиллах нь зүйтэй юм.</p> <p>Эцэг эхийн зүгээс:</p> <p>Сургуулийн гадаад болон дотоод орчны үнэлгээг хийхдээ хэрэгцээг тодорхойлон хэрэгжүүлэх, бүтээлч санал, санаачилга гарган оролцохыг эрмэлзэж байсан нь сургуулийн үйл ажиллагаа эцэг эхэд нээлттэй, ил тод болоход ихээхэн түлхэц үзүүлсэн.</p> <p>Бусад байгууллагын зүгээс:</p> <p>Эцэг эх, иргэд, олон нийтийг сургуулийн үйл ажиллагаанд татан оролцуулах, хамтын ажиллагааг сайжруулах, сургалт сурталчилгаа хийх, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн</p>
<p><i>Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс</i></p>	<p>Нийт багш, ажилтан, эцэг эх, иргэдийн хувьд хамтын ажиллагаа, бага насны хүүхдэд зориулсан эрсдэл аюулгүй орчин, хамгаалалт, түүний ач холбогдлын талаарх ойлголт харилцан адилгүй. Иймд багш, ажилтан, эцэг эх, иргэдийг нэгдсэн мэдээллээр хангаж орчны зургийг хэрхэн хийх, хяналт үнэлгээний онцлог, анхаарах асуудлыг үйл ажиллагаа эхлэхийн өмнө ухуулан танилцуулах</p> <p>Орчны аюулгүй байдлын зураглал хийх, хяналтын хуудсаар үнэлэх, дүгнэх арга зүйд багш, ажилтан, эцэг эхийг суралцуулах</p> <p>Сургуулиас эцэг эх, олон нийтийн оролцоот үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, бүхий л талаар дэмжиж ажиллах</p> <p>Байгаль, цаг агаарын болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг сайн төлөвлөх нь учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.</p>

Холбоо барих хаяг,
лого:

Чингэлтэй дүүрэг 6 дугаар хороо Лааган гудамж 50 дугаар сургууль
Захирал Б.Амар 99126047, Нийгмийн ажилтан Р.Онон 99280631, Үр
дүнд суурилсан хяналт шинжилгээ үнэлгээний багийн ахлагч
М.Эрдэнэцогт 99179623
renchindorjonon@gmail.com

**Дэмжих багийн санаачлан хэрэгжүүлсэн болон дээврийн их засварын ажлын явцын
фото зураг**

